




СОЁМЬО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.01.30 №04 (10681)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛАВ



Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд энэ сарын 24-ний өдөр Төрийн ордонд нийслэл болон аймгуудын Засаг дарга нартай 2020 онд хамтран ажиллах гэрээг байгууллаа. Энэ удаагийн хамтран ажиллах гэрээнд улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон тусгай хэрэгцээний газартай давхцуулан иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэхгүй байх, "Хүүхэд, залууст эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэх, цэргийн насны болон өсвөр үеийнхэнд цэрэг-эх оронч хүмүүжлийг олгоход чиглэсэн гурваас доошгүй ажлыг зохион байгуулах зэрэг хэд хэдэн заалт тусгагджээ.

ЭНЭ УДААГИЙН СТРАТЕГИЙН ЦУГЛАРАЛТААР ...



Жил бүрийн эхэнд уламжлал болгон явагддаг Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалт "Зэвсэгт хүчний хөгжил-стратегийн төлөвлөлт" сэдвийн хүрээнд энэ сарын 22-24-ний өдрүүдэд болж өнгөрлөө. Стратегийн цугларалтаар Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх бодлого, стратегийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, салбарын хууль, эрх зүйн орчин болон төрийн албаны шинэчлэлийн талаар дэлгэрэнгүй ярилцлаа. Цугларалтыг ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг "Геополитик, геостратегийн

орчны өөрчлөлт-Зэвсэгт хүчний байгуулалт" сэдэвт илтгэлээр эхлүүлж, бусад илтгэгч үндсэн хоёр, туслах 14 илтгэлийг хэлэлцүүлэв. Мөн энэ үеэр Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Х.Батбилэгээр дамжуулан Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүнд илгээлт хүргүүлэн цаг үеийн асуудлаар үүрэг, чиглэл өгөв. Зэвсэгт хүчний 2019 оны цэргийн алба, сахилгын дүнг ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хошууч генерал Р.Сүхбат

илтгэж, цэргийн алба, сахилгаараа тэргүүлсэн Зэвсэгт хүчний 325, 015, 084, 326, 013 дугаар ангиудад шагналыг нь гардуулсан бол Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж Батлан хамгаалах салбарын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-ийн 2019 оны ажлын тайлангаас цугларалтад оролцогчдод танилцуулж, цаашид анхаарч ажиллах зарим асуудлаар үүрэг, чиглэл өгсөн юм.

Цугларалтын төгсгөлд ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүнд өөрсдөөсөө сэтгэлгээний зэрэг өөрчлөлтийг эхлүүлэн өөрийгөө хөгжүүлэх, төрийн албаны шинэчлэлийг гүйцэтгэж ажиллах талаар үүрэг өгч, үр бүтээлтэй ажиллахыг даалгав. Дараа нь Зэвсэгт хүчний нэгтгэл, ангуудын захирагч нарын 2019 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж, 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нь баталгаажууллаа гэж ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газраас мэдээллээ.

Хошууч генерал Р.Сүхбат: ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛГО, ЗОРИЛТОО БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ БИДНИЙ ҮҮРЭГ

Зэвсэгт хүчин хэмээх их айлын чиглүүлэгч, цэргийн мэргэжлийн дээд удирдлага ЗХЖШ-ын 2020 онд дэвшүүлсэн зорилго, зорилт, үйл ажиллагааных нь төлөвлөгөөний талаар ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хошууч генерал Р.СҮХБАТТАЙ ярилцлаа.



Зэвсэгт хүчний Жанжин штаб 2020 онд ямар зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна вэ?

-Зэвсэгт хүчний Жанжин штаб нь 2020 онд Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулан, цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг тасралтгүй хэрэгжүүлж, Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавх, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилготойгоор ажиллаж байна. Энэхүү зорилго, зорилт нь мэдээж Монгол Улсын өнцөг булан бүрт эх орноо батлан хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч, ажилтан алба хаагчид болон хилийн чанад дахь энхийг сахиулагчдын маань уйгагүй зүтгэл, оролцоо, хүчин чармайлтын үр дүнд хэрэгжинэ.

Дээрх зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилтуудын талаар ...

-Хэд хэдэн үйл ажиллагааны зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Нэгдүгээрт, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх дүнд хугацааны хөтөлбөрийг стратегийн төлөвлөлтийн шинэчлэлтэй уялдуулан боловсруулж, цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг хэрэгжүүлэх, хүний нөөцийн төлөвлөлтийг төгөлдөржүүлэх, цэргийн гэрээт албыг төлөвшүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийн агуулга, стандарт, хөтөлбөрийг боловсронгуй болгох, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зэрэг олон ажил бидний өмнө бий. Мөн Төрийн цэрэгтэй холбоотой ерөнхий төлөвлөлт, дүрэм, журам, заавар, стандартыг боловсронгуй болгох, бие даан үүрэг гүйцэтгэх чадавхтай анги, салбарын тоог нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчний ар тал, техникийн хангалтын бодлого, төлөвлөлтийг эдийн засгийн бодит нөхцөлтэй уялдуулан шинэчилж, зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн хангалт, ашиглалт, засвар, үйлчилгээг сайжруулж, материал хэрэгслийн нөөцийг сольж шинэчлэн, нөхөн бүрдүүлж оновчтой байршуулах ёстой. Түүнчлэн төсөв, санхүүг үр дүнтэй зарцуулах, улс орны бүтээн байгуулалтад оролцож байгаа анги, салбарыг төлөвлөлт, зохион байгуулалтын удирдамжаар хангаж, ажлын бүтээмжийг нь дээшлүүлэх зэрэг олон зорилт бий. Эхнээсээ ажил хэрэг болоод хэрэгжээд явж байна.

Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хууль, эрх зүйн бодлогын баримт бичгүүдэд хийгдэх өөрчлөлт бий болов уу?

-2016 онд Батлан хамгаалах салбарын эрх зүйн орчин үндсэндээ төгөлдөржсөн гэж хэлж болно. Эрх зүйн шинэчлэлийн буухиа болгож 2018 онд УИХ-аас Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг шинээр батлан гаргасан. Үүнтэй уялдуулж Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх дүнд хугацааны зорилгыг хэрэгжүүлэх үүднээс "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030" бодлогын

баримт бичгийг тодорхойлууллаа. Үүний эхний шат буюу "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2016-2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг Засгийн газраар батлуулсан бөгөөд уг хөтөлбөр энэ онд дуусна. Бид үндсэндээ 2019 онд урьдчилсан үнэлгээг хийж, Батлан хамгаалахын сайд болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан байгаа. Тиймээс бид одоо дараагийн шат буюу дүнд хугацааны хөтөлбөрийг боловсруулна. Энэ нь 2020-2024 онд хэрэгжих хөтөлбөр юм. Дээр хэлсэнчлэн бидний өмнө хүлээж байгаа цөөнгүй ажилд дүнд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах тухай багтсан байгаа. Тухайлбал, эрх зүйн шинэчлэлтэй холбогдож гарсан дүрэм, журам, заавруудыг зайлшгүй батална. Үндсэндээ 70 гаруй дүрэм, журам, зааврыг батлуулах ёстойгоос 50 гаруйг нь боловсруулан тэдгээрийг үйл ажиллагаандаа мөрдүүлсэн. Нөгөө талаас Зэвсэгт хүчний өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотойгоор явагддаг цэргийн сургалт бэлтгэлийг чанаржуулах, аюулгүй байлгах тал дээр онцгой анхаарч ажиллана. Мэдээж, Зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр улс орны бүтээн байгуулалтад дахь оролцоогоо үргэлжлүүлнэ. Бидний тооцоолж байгаагаар 1, 2 дугаар сард бүтээн байгуулалтад оролцох төлөвлөлтөө хийж, 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн бүтээн байгуулагчид маань үйл ажиллагаагаа эхлүүлнэ. Эдгээр дурдаж байгаа төлөвлөгөөт ажлаас гадна олон улсын болон хоёр талын хамтарсан сургуулиуд уламжлал ёсоор явагдана. Өмнөх жилтэй харьцуулахад хэзэрийн сургуулиудын тоо нэмэгдсэнээс гадна оролцох орон, бие бүрэлдэхүүний тоо, цар хүрээ нэмэгдсэн байгаа. Мөн гаднын улсад явагдах сургуулиудад уламжлал ёсоор цэргийн алба хаагчдаа илгээнэ. Энхийг дэмжихийн чиглэлээр явагддаг сургалт, дадлага, цэргийн багуудын ажиллагааны өмнөх бэлтгэл зэргийг чанаржуулахад онцгой анхаарна. Мөн энэ жил "Олон улсын цэргийн наадам"-ын хүрээнд "Авто ралли" олон улсын тэмцээнийг Монгол, ОХУ-ын Зэвсэгт хүчин хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна гээд бидний өмнө хүлээсэн олон ажил бий.

Нэмж тодруулах зүйлийн тухайд ...

-Төлөвлөсөн ажлууд бидэнд их байна. Зэвсэглэл, техникийн шинэчлэл, цэргийн албаны сахилга, зохион байгуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талд нэлээд ахицтай жил байх болов уу гэж харж байна. Ялангуяа, цэргийн сургалт бэлтгэлийн үеэр хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, осол, зөрчлөөс өөрийгөө болон нөхдөө хамгаалахад хүн бүр онцгой анхаарах ёстой гэдгийг онцлон хэлнэ.

МОНГОЛ ЦЭРГҮҮД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЛТЭЭРЭЭ ЯМАГТ ТЭРГҮҮЛДЭГ

Энэ сарын 23-ны өдөр НҮБ-ын төв байранд "Хөгжиж буй орнуудын НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оруулж буй хувь нэмэр, сургамж, боломж" сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлгийг Монгол Улс, Жибути улс, Эль Сальвадор улсын Байнгын төлөөлөгчийн газрууд хамтран зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт НҮБ-ын Энхийн ажиллагааны газар, Ажиллагааны дэмжлэг үзүүлэх газрын зарим удирдах албан тушаалтан, НҮБ-ын дэргэд суугаа гадаадын орнуудын Байнгын төлөөлөгч, Элчин сайд, цэргийн зөвлөхүүд зэрэг 100 гаруй хүн оролцов.

Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч С.Сүхбат хэлэлцүүлгийн үеэр Монгол Улсын Засгийн газраас энхийг сахиулах ажиллагааны талаар явуулж буй бодлого, үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар болон энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэлт, НҮБ-аас тавьж буй шаардлагад бүрэн нийцэж байгаа талаар дурдсан юм. Мөн бусад орны цэргийн алба хаагчдаас үүрэг гүйцэтгэлтээрээ ямагт тэргүүлж тухайн улс оронд явуулж буй олон талт арга хэмжээ, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэн энэрэнгүй үйлс бүтээхэд үлгэр жишээ болдгийг онцоллоо.

МОНГОЛ УЛСААС НҮБ-ЫН ДЭРГЭД СУУГАА БАЙНГЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР



ШИНЭ НОМУУДАА ӨЛГИЙДӨН АВЛАА



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын даргаар ахлуулсан бүрэлдэхүүн "Агаарын цэргийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх хуулийн эмхэтгэл", "Агаарын цэргийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх эрх зүйн эмхэтгэл I, II", "Тушаалын тэмдэглэх хэсэг боловсруулах загвар" зэрэг номыг эмхэтгэн гаргалаа. Эдгээр номд Монгол Улсын Үндсэн хууль, Батлан хамгаалахын багц хууль, Улсын нисэхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль

болон Зэвсэгт хүчний анги, салбаруудын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актууд, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын Агаарын цэрэгтэй холбогдсон тогтоол, зарлиг, тушаал, шийдвэрүүд багтжээ.


"Тушаалын тэмдэглэх хэсэг боловсруулах загвар" номд Зэвсэгт хүчний ангуудын захирагч болон штабын дарга нарын бүх төрлийн тушаал, шийдвэрүүдийг холбогдох хуулийн заалттай нь үлгэрчилсэн байдлаар оруулсан байна.

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга, бригадын генерал Б.Батбаяр "Эдгээр номыг эмхэтгэн гаргаснаар Агаарын цэргийн командлал, харьяа анги, салбаруудаас гарч буй баримт бичгүүдийг ямар ч алдаагүй боловсруулах нөхцөл үүгээр бүрдэж байна. Цаашид анги, салбаруудын офицер, ахлагч нараас аливаа баримт бичгийг боловсруулахдаа хууль тогтоомж, эрх зүй, утга санаа, зөв бичих дүрэм, хэл бичгийн алдааг түгээмэл гаргадаг. Иймээс эдгээр эмхэтгэлийг ашигласнаар дээрх алдаа дутагдлууд арилахаас гадна зөвхөн Агаарын цэрэгт ч бус Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний анги, салбаруудад ашиглах бүрэн боломжтой" хэмээн онцлон тэмдэглэсэн юм.

ЭРДЭНЭСИЙН САНТАЙ МУЗЕЙ

адилтгаж болох аж. Тэрээр музейгээс зохион байгуулсан үзэсгэлэн, боловсролын ажил зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр лекц, семинарт суугаад гарч ирсэн сурагчдад үзэсгэлэнгийнхээ талаар мэдээлэл өгч, яриа таниулга хийх гэх зэргээр оюуны

Монгол цэргийн түүхэн хувьсал, замналыг иргэдэд сурталчлан таниулах, баатарлаг гавьяа байгуулсан үе үеийн эрэлхэг хөвгүүдийн үйлсийг алдаршуулан мөнхжүүлэх цэргийн түүхэнд холбогдох эд өлгийн хайгуул судалгаа хийж, сурвалжлан олох, хадгалж хамгаалах ажилд бие сэтгэлээ зориулж яваа хөдөлмөрч хамт олныг энэ удаагийн дугаартаа онцолж байна. Хил хамгаалах ерөнхий газрын зүүн талд байрлах, олны хөл үл тасрах Монгол цэргийн музейгээр хэдэнтээ ороод гарахдаа гайхширч бас бахархдаг ч тэнд ажилладаг хамт олны тухай сонирхож байгаагүй юм.



Хурандаа Д.Ганзориг

зөв байх. Москва хотын цэргийн музейгээс төлөөлөл ирж хүлээсэн үүрэг, хүсэл зорилго нэгдмэл гэдгээ илэрхийлэн хамтарч ажиллах тухай гэрээ байгуулж, музейн сан хөмрөгтэй танилцаад буцсан. Түүнчлэн дотооддоо төдийгүй ОХУ-ын Эрхүү хотод үзэсгэлэнг маань иргэд маш сайхнаар хүлээж авсан. Бид монгол цэргийн түүхийг залуу хойч үедээ сурталчлан таниулах, түүхийг үнэн зөвөөр нь ойлгуулах үүрэгтэй. Энэ ч үүргээ гүйцэтгэсэн гэдэгтээ итгэлтэй байна. Орос залуус үзэсгэлэнгээс

Тус музей МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1966 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааны тогтоолоор "Ардын Армийн төв музей" нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1996 оны 3 дугаар сарын 15-ны өдөр анхны үзэгчдээ хүлээж авсан байна. Энэ талаар Монгол цэргийн музейн захирал,



хурандаа Д.Ганзориг тун сонирхолтой түүхийг хуучилсан юм.

Тэрээр "Нэгд, миний өвөө хошууч генерал Ж.Цэнд-Аюуш МАА-ийн Улс төрийн газрын даргаар ажиллаж байхдаа МАХН-ын Улс төрийн товчооны тогтоол гаргуулж уг музейг анхлан байгуулсан. Хоёрт, би 1987 онд ЦНДС-ийн улс төрийн 3 дугаар курсийн сонсогч байхдаа бүх нийтийн субботникоор уг музейн суурийг ухаж, шавийг тавилцаж байлаа. Гуравт, тус музейн захирлаар ажиллах түүхэн үүрэг надад оногдсон жил музей маань Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан. Ийм гурван сэжмээр энэхүү музейтэй холбогдсон, энэ бүх учрал, тохиолд би их бэлгэшээж явдаг юм" гэлээ.

Мөн тэр бээр үлгэлжлүүлэн "Бид Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Монгол цэргийн түүхийг сурталчлах, судлах иргэдэд цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааг чанаржуулах, үйлчилгээний цар хүрээ, сан хөмрөгийн баяжилт, хадгалалт, хамгаалалтыг музейн стандартад нийцүүлж, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэшсэн багаар ажиллах чадварлаг хамт олныг төлөвшүүлэх зорилгыг дэвшүүлэн ажиллалаа. Өнгөрсөн он бидний хувьд баялаг амжилттай жил байсныг хэлэхэд таатай байна. Мэдээж, Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ой тохиосноороо онцлог байсан. Ойн хүрээнд тус музей иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр олон ажлын ард гарч чадлаа. Төлөвлөгөөт дөрвөөс гадна төлөвлөгөөт бус нүүдлийн 14 үзэсгэлэнг нийт 35000 иргэн үзэж сонирхсон. Түүхэндээ анх удаа жилийн төлөвлөгөөгөө 160 хувь давуулан биелүүлж, давсан орлогоо ажилтнууддаа тэнцүү хувааж өгсөн. Тэд маань ч урамшиж амжилтаа ахиулна гэсэн өөдрөг сэтгэлтэй байгаа. Мөн БСШУСЯ-наас 12 сая төгрөгийн санхүүжилт авч үзмэрүүдийн гаднах шилэн хоргонуудыг шинэчлэх, сан хөмрөгүүдийнхээ хадгалалтыг улам сайжруулж, орчин үеийн стандартын дагуу шийдэх ажлыг эхлүүлсэн. Зарим танхимыг шинэчлэн үзмэрүүдийнх нь тоог нэмээд байна. Манайх нийтдээ 9600 гаруй цуглуулгатай. Миний хувьд, хамт олон маань ч гэсэн музейгээ түүхийн эх сурвалж, эрдэнэсийн сан гэж боддог. Харин гадаад хамтын ажиллагааны талаар зарим зүйлийг онцлох нь

хоёр улсын хоорондын дипломат харилцааны өнө удаан жилийн түүх, залгамж халаа, найрсаг харилцаа, бие биеэ гэсэн тусч сэтгэлийг мэдэрсэн гэдгээ илэрхийлж байлаа. Мөн орос цэргүүд Монгол Улсын тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд, харин монгол цэргүүд Аугаа их Эх орны дайны ялалтад ямар их үнэтэй хувь нэмэр оруулсныг тэдгээр залуус ойлгож байгааг дэргэдээс нь харахад сайхан байсан" гэв. Үнэхээр ч түүний ярьж хэлсэн зүйлс, хамт олных нь хийж хэрэгжүүлсэн ажлаас нь улс хоорондын гадаад харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд Монгол цэргийн музей багагүй үүрэг гүйцэтгэсэн нь илхнээ мэдрэгдэж байв.

Музейн уран зургийн сан хөмрөгт ямар ч үнээр худалдаалсан ч хайран санагдах хосгүй бүтээлүүд хадгалагддаг. Бүгдийг нь зориулалтын гүйдэг замтай болгосон байлаа. Мөн Монгол цэргийн дүрэмт хувцасны сан хөмрөгийг баяжуулан хувцас нэг бүрийг хадгалалтын шинэ стандартаар болгохоор зорьж байгаа аж.

Музейн хамт олон цаг үе, залуусын сэтгэлгээ өөрчлөгдөж байгааг соргоогоор мэдэрч арга барилаа шинэчлэн гэрэл зураг, ханын самбар гэхгүйгээр Баянцагааны тулалдааныг харуулсан диаграммыг богино хугацаанд хийж гүйцэтгэсэн агаад газраар хөглөрөх сумны хонгио, гэдэргээ унасан дуулга, тоосонд дарагдсан нуувч, тулаад харвал жинхэнэ мэт санагдах ногоон шинель өмсөж буугаа барьсан цэргүүд зэрэг нь онцгой сэтгэгдлийг төрүүлж тухайн цаг үеэр аялуулах шиг болсон шүү.

Тус үзмэрийн баруун гар талд Шинэ түүхийн танхим, Төрөл мэргэжлийн танхим байрладаг. Эдгээр танхимаар зочлоход Богд хаант Монгол Улсын цэргийн түүхээс эхлээд өнөөдрийн Зэвсэгт хүчний шинэчлэл, дайчин уламжлалыг харж болох аж. Мөн БНМАУ-ын баатар Ш.Гонгорын хэрэглэж байсан офицер сэлэм цаанаа л нэг сурдмээр. Удаан ажваас өөрийгөө ч тольдож болохоор тунгалаг харагдахаас гадна уран нарийн хийц нь монгол цэргийн дайчин уламжлал, сүр жавхааг аргагүй илтгэнэ. Хажууханд нь Барилгын цэргээс төрсөн Батлан хамгаалах яамны сайд, хурандаа генерал, Ж.Лхагвасүрэн агсны дүрэмт хувцас, бээлий мөн Улсын баатлан хамгаалах болон Батлан хамгаалах яам, Цэргийн явдлын яамны тэмдгүүд он дарааллаараа байхаас гадна Монгол Улсын Зэвсэгт хүчний шинэчлэлийг харуулсан түүхэн

зургууд ч бий. Харин Төрөл мэргэжлийн танхимд хэт богино долгионы радио станц, ЗХУ-д үйлдвэрлэгдсэн артиллерийн хол хэмжигч, хээрийн радио холбоо, зенитийн пуужингийн зөөврийн цоцолбор зэрэгтэй танилцах боломжтой.

1911 оноос өнөөг хүртэлх Монгол Улсын төрийн сүлд, далбааны өөрчлөлтийг харуулсан Хүндэтгэлийн танхимд манай улсын түүхэнд мөнхөрсөн гурван маршал буюу Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал Г.Дэмид нарын хэрэглэж байсан эд зүйлс, хувцас, бусад холбогдолтой баримт бичгийг дэлгэн үзүүлсэн байлаа. Тухайлбал, маршал Х.Чойбалсангийн өмсөж байсан дүрэмт хувцасны доор "Энэхүү дүрэмт хувцасны загварыг Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 22 дугаар тогтоолоор баталсан" гэсэн бол түүний хэрэглэж байсан бичгийн машиныг 1945 оны Чөлөөлөх дайны дараа "Монголын цэргүүд баяр хүргэж өөрсдөө дархны аргаар урлан бүтээсэн" хэмээн тайлбарыг хавсаргаж англи хэлнээ бас хөрвүүлжээ. Танхимын хамгийн отгон үзмэр нь Халхын голын байлдааныг харуулсан макет байв. Баруун гар талд Японы арми хориглож, харин зүүн гар талаас морьт болон явган цэрэг, танкийн хороотойгоор тэргүүн эгнээг алаг морьтой Л.Дандар баатар ахлан давшилтад орж байгаагаар дүрсэлсэн байна. Мөн цэлмэг тэнгэрт дүүлэх шонхруудын тулааныг ч харж болно. Сонирхуулахад, БНТУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.Ахмет Язал өөрийн санаачилгаар дээрх макетын загварыг боловруулсан бөгөөд уран барималчдын туслалцаа дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгээд Монгол цэргийн музейд хүлээлгэж өгсөн аж.

Музейн ажилтнуудын тодорхой хэсэг нь залуусаас бүрддэг. Сүүлийн жилүүдэд ч музейд ажиллах хүсэл сонирхолтой залуусын тоо нэмэгдсээр байгаа аж. Энэ талаар музейн удирдлагуудаас тодруулахад "Ахмад, залуу үеийн хоорондын эргэх холбоо гэж чухал зүйл бий. Олон жилийн мэдлэг, туршлагаа залуу хойч үедээ уламжлуулаад явбал тун зүгээр. Бидний барьж буй нэг бодлого нь залуусыг ажлын байран дээр нь чадавхжуулж, тогтвор, суурьшилтай ажиллах бололцоог нь бүрдүүлэх явдал юм. Ингэснээр тухайн ажилтан эрхэлсэн ажилдаа хэнээс ч илүү мэргэшинэ. Ингээд хэвшчихвэл хүн нэг бүрийн ажлын бүтээмж эрс дээшилнэ" гэсэн юм.

Хуучин чулуун зэвсгийн дээд үеэс XX зууны эхэн үе хүртэлх монгол цэргийн түүхэнд холбогдох зэр зэвсэг, эд өлгийн зүйлс Эртний түүхийн танхимд хадгалагддаг. Манай улс Түрэгийн үед хамаарах олдвор, эд өлгийн зүйлсээрээ Турктай холбогддог. Энэ ч утгаараа эртний түүхийн танхимыг Туркийн засгийн газрын "ТИКА" төслийн хүрээнд шинэчлэх асуудлыг хоёр улсын яамд хоорондын зөвлөлдөх уулзалтаар хэлэлцэнэ гэдгийг музейн удирдлагууд онцолсон.

Тус музей нийгмийн хариуцлагынхаа хүрээнд ч багагүй ажлыг амжуулсан байна. Онцолбол, ОХУ-ын ЭСЯ-ны хамтын ажиллагааны хүрээнд Орос 14 дүгээр сургуулийн сурагчдад музейг үнэ төлбөргүй үзүүлдэг болсноос гадна 2014 оноос эхлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайль үсгэн болон дохионы хэлний тайлбарыг үйлчилгээндээ нэвтрүүлээд байгаа юм.

Аж ахуйн үйлчилгээ, аюулгүй байдлын алба нь музейн болон сан хөмрөгийн үзмэрүүдийн аюулгүй байдлыг хангаж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, байгууллага, үзүүлэлийн танхимын өнгө үзэмж, тохижилтыг сайжруулах, ажлын тав тухтай орчныг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй.



Д.Сарантулга

Тэд 2019 оны төлөвлөгөөний биелэлтээ бүрэн дүүрэн хангасан амжилттайгаар шинэ оноо угтсан бөгөөд сүүлийн 20 жилийн "толгойны өвчнөөсөө" салжээ. Энэ талаар тус албаны дарга, хөдөлмөр хамгааллын байцаагч Д.Сарантулга "ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, Монгол Улсын баатар, маршал Г.К.Жуковын дурсгалын музейн дулааны шугамыг солих ажлыг БХЯ-ны хавьяа Барилга захиалагчийн

албатай хамтарч оны өмнөхөн хийж гүйцэтгэсэн. Батлан хамгаалах яам дэмжлэг үзүүлсэнд талархаж байгаагаа илэрхийлэе. Мөн Монгол цэргийн музейн дулааны үзэлийг өөрсдийн нөөц бололцоогоороо шинэчиллээ. 2020 онд шат дараалсан ажлуудыг төлөвлөсөн. Тухайлбал, Аугаа их эх орны дайны болон Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойг угтсан үзэсгэлэнгүүдэд манай алба тэргүүн фронтод ажиллах ёстой" гэв. Д.Сарантулгын хувьд Батлан хамгаалахын төв архивт олон жил үр бүтээлтэй ажиллаад цэргийн алба хаасны тэтгэвэртээ гарчээ. Дараа нь ажлын туршлагаа бусадтайгаа хуваалцах нь зүйтэй гэж үзээд удалгүй эл музейд үргэлжлүүлэн ажиллахаар болсон байна. Хамт ажилладаг залуус нь ч түүнийг ихэд хүндэтгэхийн зэрэгцээ дотно зөвлөгч нь байдаг үргэлж талархдаг гэнэ.



Д.Баянжаргал

Музейн ажилтнуудын тодорхой хэсэг нь залуусаас бүрддэг. Сүүлийн жилүүдэд ч музейд ажиллах хүсэл сонирхолтой залуусын тоо нэмэгдсээр байгаа аж. Энэ талаар музейн удирдлагуудаас тодруулахад "Ахмад, залуу үеийн хоорондын эргэх холбоо гэж чухал зүйл бий. Олон жилийн мэдлэг, туршлагаа залуу хойч үедээ уламжлуулаад явбал тун зүгээр. Бидний барьж буй нэг бодлого нь залуусыг ажлын байран дээр нь чадавхжуулж, тогтвор, суурьшилтай ажиллах бололцоог нь бүрдүүлэх явдал юм. Ингэснээр тухайн ажилтан эрхэлсэн ажилдаа хэнээс ч илүү мэргэшинэ. Ингээд хэвшчихвэл хүн нэг бүрийн ажлын бүтээмж эрс дээшилнэ" гэсэн юм.

Д.Баянжаргал 2017 оноос хойш Монгол цэргийн музейд Боловсролын ажилтан-тайлбарлагчаар ажиллаж байна. Түүний ажлыг багшийн ажилтай

хөрөнгө оруулалт хийдэг аж. Энэ нь хичээлээр олж авсан мэдлэгийг нь бататгах ач тустай гэлээ.

Хүний нөөц, архив, бичиг цэргийн эрхлэгч, номын санч гээд олон ажлыг хавсран гүйцэтгэдэг энэ эмэгтэйг Б.Оюунцэцэг гэдэг. "Саяхан музейд ажилд орох гээд өргөдөл, баримт бичиг гээд явж байсан сан. Харин одоо музей маань шижигнэсэн залуусаар дүүрээд би гэдэг хүн ахмадуудын тоонд шилжлээ. Монгол цэргийн музей бол соёлын үнэт өвийг тээж хадгалдаг, түүхийн хөдөлшгүй эх сурвалж бодгийнхоо хувьд онцлогтой байгууллага. Миний хувьд энд ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байдаг" гэв.

Б.Оюунцэцэг музейд өнгөрүүлж буй 12 жилийн хугацаандаа цөөнгүй дарга, менежертэй гар нийлэн ажиллажээ. Энэ тухайгаа "Хамт



Б.Оюунцэцэг

ажиллаж байсан дарга, менежер, ажилтнууд дээшээ дэвших нь их. Ер нь хамт ажиллаж байсан дарга нар маань бүгд л тэгсэн байх юм. Би үүнд их бэлгэшээж явдаг даа" гэсээр бидний яриа өндөрлөсөн юм.



БНМАУ-ын баатар Ш.Гонгорын офицер сэлэм



Халхын голын байлдааныг дүрсэлсэн макет



Цэрэг эмээл



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 340 ДҮГЭЭР АНГИ 10 ЖИЛ

МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмрээ оруулж, монгол цэргийн түүхийг бахархам үйлсээр баяжуулан дархалж яваа Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн үе үеийн удирдлага, ахмад дайчид, ажилтан албан хаагчид болон алба хааж буй нийт бие бүрэлдэхүүн та бүхэнд анги үүсэн байгуулагдсаны тань 10 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлэе.

Тус анги байгуулагдсан цагаасаа эхлэн Зэвсэгт хүчний өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, Зэвсэгт хүчний "Тэргүүний анги"-аар хоёр удаа, "Сургалт бэлтгэлээр хошуучлагч анги"-

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ, БРИГАДЫН ГЕНЕРАЛ Б.АМГАЛАНБААТАР

аар хоёр удаа, "Сахилгын зөрчилгүй тэргүүний анги"-аар нэг удаа шалгарч, эх орныхоо бүтээн байгуулалт, гамшгийн үед иргэдийн амь нас, өмч хөрөнгийг авран хамгаалах эрхэм үйлсэд хүчин зүтгэж, хувь нэмрээ оруулсан төдийгүй НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд үүргээ нэр төртэй гүйцэтгэн, Монгол Улсын нэр хүндийг дэлхий дахинд мандуулах үйлсэд амжилт гаргаж буй танай ангийн хамт олны амжилт, бүтээлийг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын удирдлага өндөрөөр үнэлж, бахархан хүндэтгэдэг билээ.

Та бүхэнд хүрсэн амжилтаа улам бататгаж, цэргийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, эх орноо батлан хамгаалах ариун үйл хэргээ үнэнчээр биелүүлж, хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэх чадвахаа улам дээшлүүлэн, сургалт бэлтгэлийн түвшингээр ямагт манлайлагч байж, улс орныхоо бүтээн байгуулалтын ажилд үнэтэй хувь нэмрээ оруулахын ерөөлийг өргөн дэвшүүлэе.

Монгол цэргийн цог золбоо, сүлд хийморь үеийн үед мандан бадрах болтугай.

Эх орноо батлан хамгаалах эрхэм үйлсэд хүчин зүтгэж, эрдэм ухаан, хөдөлмөр зүтгэлээ зориулсан ахмад дайчид, энх цагийн бүтээн байгуулалт, Зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх үйлсэд залуу нас, эрдэм мэдлэгээ зориулж ирсэн үе үеийн офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчид та бүхэндээ Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн яруу алдрын түүхийг бүтээсэн 10 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлэе.

Бид өвөг дээдсийнхээ халуун амь, бүлээн цусаар гэрээслэн үлдээсэн Монгол Улсынхаа халдашгүй дархан байдлыг батлан хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж, төр, засаг, Зэвсэгт хүчин, Хуурай замын цэрэг, ангийнхаа зорилго, зорилтыг бүрэн хэрэгжүүлж, эх орныхоо бүтээн байгуулалтад хүчин зүтгэж байгаа төдийгүй НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцож, даян дэлхийд энх тайвныг мандуулж буй амжилт, бүтээлээр дүүрэн ангийнхаа түүхт ойтой золгож байна.

Бахдам түүхийг бүтээсэн энэхүү 10 жилийн өнгө төрх, амжилт бүтээл бол тус ангийн үе үеийн чадварлаг удирдлага, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчид болон одоо ажиллаж байгаа бие бүрэлдэхүүн та бүхний минь ажил хөдөлмөртөө хандсан сэтгэл, зүтгэлийн үр дүн гэдгийг бахархалтайгаар тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Төрөлх ангийнхаа түүхт 10 жилийн ойг тохиолдуулан залуу нас, эрч хүч, хөдөлмөр



зүтгэлээ зориулсан эрхэм хүндэт генерал, офицер, ахлагч, ажилтан албан хаагч, хугацаат албаны түрүүч, байлдагч, хилийн чанадад үүрэг гүйцэтгэж Монгол Улсынхаа нэр хүндийг дэлхий дахинд мандуулж яваа эрэлхэг дайчин энхийг сахиулагч та бүхэндээ ангийн захирагчийн зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувийасаа чин сэтгэлийн халуун мэндийг дэвшүүлж, ажил хөдөлмөрт тань өндөр амжилт, амьдралд тань эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэж, зуун зуунаар дуурсагдах их бүтээн байгуулалтын ажилд тань арвин амжилтыг хүсэн ерөөе.

Монгол цэргийн золбоо хийморь үеийн үед мандан бадрах болтугай.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 340 ДҮГЭЭР АНГИЙН ЗАХИРАГЧ, ХУРАНДАА Б.ДОРЖДЭРЭМ

ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, Батлан хамгаалахын сайдын болон Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар Зэвсэгт хүчний 340 дүгээр анги нь 2010 оны 7 дугаар сарын 1-ний өдөр байгуулагдан Тавантолгой дахь Сургалтын нэгдсэн төвд анхны сууриа тавьсан ба 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотоос 1700 километрийн алсын маршийг зургаа хоногийн хугацаанд үйлдэн Баян-Өлгий аймгийн төвд "Улс орны бүтээн байгуулалтын ажил болон энхийг дэмжих ажиллагаанд оролцох чиг үүрэгтэй"-гээр анх байгуулагдсан түүхтэй. Улмаар цэргийн ангийн дайчин уламжлал, эх орноо хамгаалах ариун үүрэг, цэргийн нэр төр, алдар гавьяаны илэрхийлэл болсон Байлдааны тугаа 2011 оны 2 дугаар сард хүлээн авсан юм. Анги байгуулагдсан цагаас хойш мэргэжлийн боловсон хүчин, өндөр хүчин чадалтай замбарилгын техникээр тасралтгүй хангагдаж, Зэвсэгт хүчний нэр хүндийг алс баруун хязгаарт өндөрт өргөж яваа нь үе үеийн захирагч нарын мэдлэг, чадвар, бие бүрэлдэхүүний хичээнгүй хөдөлмөрийн үр дүн билээ. Тус ангийн анхны захирагч асан, ангиас төрсөн бригадын генерал П.Доржсүрэн нь өдгөө Зэвсэгт хүчний Ерөнхий хянан шалгагч, Ханалт шалгалт үнэлгээний газрын дарга, хоёр дахь захирагч, дэд хурандаа У.Буянжаргал нь Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын даргаар томилогдон эх орноо батлан хамгаалах эрхэм үйлсэд эрдэм ухаан, хөдөлмөр



зүтгэлээ зориулан ажиллаж байна. Ангийн бие бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлаа байнга дээшлүүлэхийн зэрэгцээ баруун бүсийн томоохон бүтээн байгуулалтын ажлуудад байгуулагдсан үеэсээ эхлэн оролцож, Баян-Өлгий аймаг дахь Тагнуулын газар, Асгатын мөнгөний орддын зам, гүүрийн ажил, Өлгий сумын 4 дүгээр багийн 50 ортой хүүхдийн цэцэрлэг, Толбо, Алтай, Булган, Цагааннуур сумын цагдаагийн кабон, Өлгий сумын 2 дугаар бага сургуулийн спорт заал, Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн спорт заал, цэргийн гал тогоо, халуун ус, шалган нэвтрүүлэх байр, уурын зуух, албан тушаалын 40 айлын орон сууц, Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн штаб, шалган нэвтрүүлэх байр, гал тогоо, уурын зуух, албан тушаалын 40 айлын орон сууц, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Хүчирхийлээс хамгаалах төв зэрэг 33 объектыг

шинээр барьж, 18 гаруй барилга байгууламжийн засвар, шинэчлэлийн ажлыг гүйцэтгэн эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулсан юм.

Түүнчлэн дэлхийн хүн төрөлхтний амар амгалан, энх тайван амьдралыг батлан хамгаалах их үйлсэд манай ангийн алба хаагчид өөрсдийн хувь нэмрийг оруулсаар байна. Өдгөө тус ангийн бие бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар улс орныхоо бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Таван толгой-Зүүнбаян чиглэлд төмөр замын ажилд томилогдон үүргээ амжилттай гүйцэтгэж байгаа билээ. Ангийн нийт бие бүрэлдэхүүн "Зэвсэгт хүчний тухай" болон бусад хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн дэвшүүлсэн зорилго, зорилтоо бүрэн дүүрэн хэрэгжүүлж, эх орны хөгжил цэцэглэлт, батлан хамгаалах үйлсийн төлөө хичээнгүйлэн зүтгэж байна.

АНГИЙН ОЛОЛТ АМЖИЛТ



Ангийн барилгачин дайчид, инженерүүдийн ур ухаан, хичээл зүтгэл, идэвх санаачилга, хөдөлмөр бүтээлээр сүндэрлэн боссон бүтээн байгуулалтын ажил, сургалт бэлтгэл, бэлэн байдлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб өндөрөөр үнэлж 2010 оны Зэвсэгт хүчний "Тэргүүний тохижилттой анги", 2012 оны Зэвсэгт хүчний "Тэргүүний анги",

2013 оны Зэвсэгт хүчний "Хошой тэргүүний анги"-аар шалгаруулсан бол 2017 онд Баян-Өлгий аймгийн "Барилгын салбарын шилдэг норм, норматив төлөгч аж ахуйн нэгж"-ээр тодорсон юм.

Мөн ангийн бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн чанарыг дээшлүүлэх ажлыг үр дүнтэй биелүүлж 2016 оны 4 дүгээр сард явагдсан Зэвсэгт хүчний Жанжин штабын цогцолбор шалгалтаар "Сургалт бэлтгэлээр хошуулагч анги", 2016 оны 7 дугаар сард явагдсан Зэвсэгт хүчний ХШУГ-ын төлөвлөгөөт шалгалтад "В", 2018 онд хуулиар хүлээсэн үндсэн болон тайван цагийн үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлж, цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн дүнгээр амжилттай шалгагдан "Сургалт бэлтгэлээр хошуулагч анги", 2018 онд Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын дунд явагдсан "Сахилгын зөрчилгүй тэргүүний анги" шалгаруулах уралдаанд амжилттай оролцож хоёрдугаар байрыг тус тус эзэлсэн.

Баян-Өлгий аймаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд жил бүр зохион байгуулагддаг "Марш тактик, тусгай бэлтгэлийн аварга тасаг" шалгаруулах тэмцээнд 2011 онд хоёр, 2012, 2013, 2016, 2017 онд нэг, 2015, 2018 онд гуравдугаар байруудыг тус тус эзэлсэн нь зөвхөн бүтээн байгуулалтаар биш цэргийн мэдлэг, чадвараараа ч тэргүүлдгийг харуулсан амжилт билээ.

Батлан хамгаалах яам ангийн захирагч, хурандаа Б.Дорждэрэмийг 2017 оны Батлан хамгаалах салбарын "Тэргүүний офицер"-оор шалгаруулсан нь ангийн нийт бие бүрэлдэхүүний өргөсөн тангарагтаа үнэнч байж, улс орны бүтээн байгуулалтын ажилд идэвх санаачилга, өндөр бүтээмжтэй оролцож байгааг үнэлсэн шагнал юм.

ХУВЬ ХҮНИЙГ ХӨГЖҮҮЛЖ ЧАДДАГ ХАМТ ОЛОН

Миний бие Ховд аймгийн Манхан суманд 1966 онд төрсөн. 1984 онд цэргийн албанд татагдаж Ардын Армийн 013 дугаар ангийг хуваарилагдаж цэргийн алба хаасан. 1985 онд Офицеруудын мэргэжил дээшлүүлэх курсийг төгсөж Зүүнбаян дахь Зэвсэгт хүчний 126 дугаар нэгтгэлд станцын дарга-жолооч, салааны захирагч, салбарын техникийн орлогч, суурин зангилааны дарга, инженер зэрэг алба хашиж байгаад 2010 онд Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийг холбоо мэдээллийн офицероор томилогдон ажилласан юм. Тус ангийн холбооны тасгийн бүрэлдэхүүн байнгын утас болон радио холбоог зохион байгуулж, удирдлагыг тасралтгүй найдвартай холбоогоор ханган ажиллаж байлаа. Баян-Өлгий аймгийн Холбооны газраас ангийн байрлал хүртэл цахилгаан холбооны шугам татах ажлыг биечлэн гүйцэтгэж ангийг суурин утас тавьж, интернетын сүлжээг байгуулж билээ. Түүнчлэн Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын нутагт хугацаат цэргийн хоёр алба хаагчийн хамт зун, намрын халуун болон шумуулж үл ажран ногоо тариалж байсан дурсамжууд бий.

Ангийн хугацаат цэргийн алба



хаагчдын мал, мах бэлтгэлийн ажилд комиссын даргаар томилогдон Увс аймгийн зарим сумдаар явж, мал тууварлан ирдэг байлаа. Мөн "Цэргийн бэлтгэл үүрэгтнийг давтан сургах сургалтын төв"-ийн захирлаар томилогдон ажиллаж байсан. Сургалтад хамрагдаж байсан нутгийн иргэдийн нэрийг нь би тогтоохгүй, зарим нь монголоор ярьж мэддэггүй бэрхшээлийг эс тооцвол сургалт маань чанартай зохион байгуулагдсан.

Миний оролцоотойгоор Холбооны тасгийн бүрэлдэхүүн маань ангиас зохион байгуулсан уралдаан тэмцээнүүдэд байнга идэвх, зүтгэлтэй хамрагддаг байлаа.

Би бээр дээрх ажлуудыг хийж гүйцэтгэх, анхдагч суурийг тавилуу дэмжлэг үзүүлж байсан ангийн удирдлага, офицер, ахлагч, ажилтан албан хаагч, цэрэг, түрүүч нараараа ямагт бахархаж явдаг. 2011 онд тэтгэвэрт гарч, ангийн анхны ахмад дайчин болсон нь бас онцгой тоиолдол гэж боддог. Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийг ажиллаж байсан генерал, офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагч, ажилтан, одоо ажиллаж буй нийт бие бүрэлдэхүүндээ ангийнхаа 10 жилийн ойн баярын цогтой халуун мэндийг хүргэе.

Бэлтгэл хошууч Н.ЛХАГВАДОРЖ

БИД ИХ ЗҮЙЛИЙГ БҮТЭЭСЭН

Алс баруун хязгаарт шинээр байгуулагдсан Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийг ерөнхий инженерээр томилогдон, 2011 оны 6 дугаар сарын эхэнд аймгийн Тагнуулын газрын барилгыг богино хугацаанд барьж мөн ондоо багтаан ашиглалтад оруулах, баруун бүсийн болон орон нутгийн бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэх үүргийг биелүүлэхээр шамдсан юм. Улмаар тус барилгын ажлын зурагтай танилцаж материалын тооцоог нь гарган хэрэгцээт арматураа захиалан ачуулаад аймагт очиход Ховд голоо даган сунаж байрласан намхан навтгар амины байшин ихтэй өндөр уулсаар хүрээлэгдсэн цэнгэг агаар нь сэнгэнэсэн сайхан нутаг тосч билээ.

Манай залуу хамт олон богино хугацаанд атгасан гар шиг нягтарснаар цэргийн хэрэг, бүтээн байгуулалт, спорт, уран сайхнаар амжилт гаргаж ёстой уулыг нурааж усыг эргүүлэх хүчтэй болж чадсан. Энэ ч чанараараа Тагнуулын газрын төвөгтэй хийц бүхий шилэн нүүртэй барилгыг товлосон хугацаанд нь онц дүнтэй ашиглалтад оруулж, тус барилгыг хүлээн авахаар ирсэн Тагнуулын Ерөнхий газрын дарга Р.Болд Зэвсэгт хүчний анги үнэхээр хийж чадаж байгааг онцлон тэмдэглэсэн юм. 2012 онд Булган, Цагааннуур, Алтай, Толбо, Буянт сумдын цагдаагийн кабоны барилга, ангийн гал тогоо, цэргийн байр, аймгийн Цагдаагийн газрын барилгын засвар, амины орон сууц зэргийг барьсан юм.

Мөн Асгатын мөнгөний орддын 83 метр урттай төмөр бетон гүүр, 3,72 километр сайжруулсан хайрган хучилттай авто замыг өвлийн хүйтэн,



цасан шуурга зэрэг байгалийн бэрхшээлийг үл ажран төлөвлөсөн хугацаанаас нь өмнө ашиглалтад онц дүнтэй өгсөн бахархам амжилтыг гаргаснаар тус анги ямар ч ажлыг гүйцэтгэх мэргэжилтэй боловсон хүчин, санхүү, хөрөнгө материал, техник тоног төхөөрөмжийн хувьд бүрэн боломжтой болж билээ. Түүнчлэн ангийн хашааг өргөтгөн спорт заалны барилгын суурь, Сагсай сумын уулын ротын барилгын засвар, "Памукали" рестораны өргөтгөл, тоосгон зааводын

баюу барих, хар уулын төмөрлөгийн үйлдвэрийн суурийн ажил зэргийг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Ийм л бүтээлч хамт олонтой ажилласан миний хувь нэмрийг Зэвсэгт хүчний удирдлага өндөрөөр үнэлсэн бөгөөд улмаар Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн захирагчаар дэвшүүлэн томиловсон юм. Миний хувьд ангийн орлогч нар болон албад, салбарын дарга нартай ажлын нягт уялдаа холбоотой ажиллаж байсны дотор штабын дарга, хошууч Б.Дорждэрэм /одоо ангийн захирагч, хурандаа/-тэй олон ажлын ард хамтдаа гарч байснаа дурсахад таатай байна.

Ангийнхаа хамт олонд анги үүссэн байгуулагдсаны 10 жилийн ойн баярыг тохиолдуулан сайн сайхныг хүсье.

Монгол Улсын Зөвлөх инженер, бэлтгэл хурандаа Д.НЯМСҮРЭН

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 340 ДҮГЭЭР АНГИ 10 /ЖМЛ



АНГИЙН ЗАХИРАГЧ НАР

Бригадын генерал П.Доржсүрэн нь 1960 онд Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотод төрсөн. 1981 онд ЦЕДС-ийн офицерын курс, 1992 онд ЗХУ-ын инженерийн дээд сургууль, 2000 онд ОХУ-ын Инженерийн академийг тус тус төгссөн. Цэргийн шинжлэх ухааны магистр. 1981-1983 онд Зэвсэгт хүчний 131 дүгээр ангийн салаа, ротын захирагч, 1983-1987 онд Зэвсэгт хүчний 126 дугаар нэгтгэлийн инженерийн албаны даргын туслах, ахлах туслах, 1992-1993 онд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн инженер сапёрын батальоны захирагч, 1993-1997 онд БХЯ-ны 5 дугаар хэлтэст офицер, ахлах офицер, 2001-2006 онд Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн захирагч, 2006-2008 онд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагч, 2008-2009 онд БХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академийн багш, 2009-2010 онд Зэвсэгт хүчний Жанжин штабын Хүний нөөцийн хэлтсийн дарга, 2010-2014 онд Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн захирагч, 2014 оноос Зэвсэгт хүчний Ерөнхий хянан шалгагч, Хяналт, шалгалт үнэлгээний газрын даргаар томилогдон ажиллаж байна.



Дэд хурандаа У.Буянжаргал нь 1978 онд Дорноговь аймгийн Сайншанд суманд төрсөн. 1986-1996 онд Дорноговь аймгийн 2 дугаар 10 жилийн дунд сургууль, 1996-2001 онд БХИС-ийг зам, гүүрийн барилга, машин механизмын ашиглалтын инженер мэргэжлээр, 2015-2017 онд БХИС-ийн БХУА-д тус тус суралцаж төгссөн. 2001-2004 онд Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн гүүр, ус гатлалтын ротын захирагч, 2004-2005 онд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн сургагч багш, 2009-2010 онд Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн хуягт танкийн дарга, 2010-2011 онд Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн инженерийн хангалтын офицер, 2011-2013 онд цэргийн хангалт, үйлчилгээний тасгийн дарга, 2013-2014 онд захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, 2014-2015 онд захирагч, 2017 оноос Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын даргаар томилогдон ажиллаж байна.



Хурандаа Б.Дорждэрэм нь 1979 онд Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд төрсөн. 1986-1996 онд Баруун-Урт сумын 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 1996-2001 онд БХИС-ийг зам гүүрийн барилга, машин механизмын ашиглалтын инженер, инженерийн цэргийн командын офицер мэргэжлээр, 2005-2006 онд Цэргийн дээд сургуулийг ерөнхий цэргийн командын офицер, 2013-2015 онд БХИС-ийн БХУА-ийг стратегик-тактик, команд штабын мэргэжлээр төгссөн. 2001 онд БХУА-ийн ротын захирагчийн дамжаа, 2006 онд БХИС-ийн ЦДС-ийн Цэргийн бакалаврын дамжаа, 2003 онд БХИС-ийн франц хэлний дамжаа, 2008 онд ЗХЖШ-аас зохион байгуулсан тактикийн багшийн дамжаанд суралцсан. 2001 онд Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн салааны захирагч, 2001-2003 онд инженер сапёрын ротын захирагч, 2003-2006 онд инженер сапёрын гэрээт цэргийн ротын захирагч, 2006-2009 онд инженерийн эд хэрэглэл, галт хэрэглэлийн инженер, 2009 онд тусгай үүргийн төлөвлөлтийн офицер, 2010-2013 онд Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, 2015 оноос Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн захирагчаар томилогдон ажиллаж байна.



АНХНЫ ЗАХИРАГЧААР ТОМИЛОГДСОНООРОО БАХАРХДАГ

Би Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотын дунд сургуулийн 8 дугаар ангийг дүүргэсэн. Ангидаа нэлээн сахилгагүй байсан тул хэсэг "болдоггүй" хүүхдүүдийг Барилгын техник мэргэжлийн сургууль /ТМС/-д явсан ба Сэлэнгэ аймгийн Номгоны сангийн аж ахуйд барилгачнаар илгээлтээр очиж, шинэ сангийн аж ахуйн тулгын чулууг тавилцсан юм. Тэр үедээ гайгүй ажилласан юм байлгүй, нэг өдөр сангийн аж ахуйн дарга Н.Пэрэнлэй гуай дуудаад "Чи Шаамарт тракторын ТМС-д сурч, трактор-комбайнч болох уу?" гэхэд нь угаасаа техникийн сонирхолтой хүн чинь дуун дээр нь "За" гэсэн. Тэгээд хоёр дахь ТМС-иа төгсөөд сангийн аж ахуйд трактор-комбайнчаар ажиллах үедээ буюу өвөл ажил бага үед Зүүнхараад 10 дугаар ангийг эчнээгээр төгссөн дөө. Тэр үед трактор-комбайнчдыг цэрэгт татдаггүй байлаа. Нэг өдөр оргож, цэрэгт явсан ба Зэвсэгт хүчний 065 дугаар ангид хугацаат цэргийн албаа хааж эхэлсэн юм. Мэдээж, хар багаасаа гэр орноосоо хол явсан хүн цэргийн албанд түүрэхгүй амархан дассан. Тэр үед хугацаат алба нь гурван жил байсан ба би гайгүй зурж, шрифтер бичдэг болохоор өдөр нь танхим тохижуулж, шөнө нь халагдах цэргийн альбом хийдэг байв. Жил өнгөрч байтал ангийн захирагч, хурандаа Балдан дуудаж "Чи офицер болох сонирхолтой юу?" гэж асуусан. Миний аав 1939, 1945 онд хорооны эмч, хошууч цолтой дайнд явж байсан бөгөөд манай хамаатан садны дунд таван хурандаа, нэг гавьяат бий. Тэгээд би ангийн захирагчаар "Тэгье" гэснээр Цэргийн нэгдсэн дээд сургуульд нэг жил суралцаж Зүүнбаянд бага дэслэгч цолтой салааны захирагчаар томилогдон, офицерын ажлын анхны гараагаа 1981 онд эхэлсэн юм. Тэр үед аав маань маш их баярлаж билээ. Эхэндээ жагсаалын өмнө үүрэг тавихад хэл, ам гацаад хэцүү байсан. Ядаж байхад тэд надаас ах, үе тэнгийн, энэ юу ярих нь вэ гэсэн байдалтай сонжсон харц угтаж, би ч аль болох тайван байхыг хичээн үгээ цэгнэн ярьж ажлаа эхлүүлсэн юм. Монголын Ардын Арми тэр үед корпусаас армийн бүтцэд шилжин, шинээр дэлгэж байсан болохоор манай хорооны инженерийн рот бараг офицергүй шахам байсан. Тухайн үед ажлын эхлэл, хамт ажиллах бага дарга нараа Зүүнхараагийн цэргүүдээс сонгосон нь дээр юм байна гэдгээ хошууч Хандмаа даргадаа илтгээтэл зөвшөөрч, үүний үр дүнд салаа маань тэргүүний салаа болж, тун удалгүй би ротын захирагч болсон юм. Миний цэргүүд надад хайртай, өгсөн үүрэг даалгаврыг цагт нь гүйцэтгэдэг сэргэлэн залуучууд байв. Би бээр ангийн захирагч, хошууч Хандмаагаас их зүйлийг сурсан. Захирагч маань бидэнд "Цэргийг ходоодоор нь нь хүмүүжүүлдэг юм" гэдэг байлаа. Энэ нь чиний хариуцсан цэргийн алба хаагчийн ахуй нөхцөл нь ямар байгаа, тэдний үр хүүхэд нь юу идэж байгаа, амьдрал ахуй нь ямар байна гэдгийг мэдэрч судлах ёстой. Боломж байвал тэдэнд тусалж, анхаарал сайн тавих хэрэгтэй. Тэгээд дараа нь ажлаа шаард гэдэгсэн. Би энэхүү зарчмыг 40 орчим жилийн албандаа мөрдөж ирсэн дээ. Ангийн захирагч маань Улаанбаатар хот руу дэвшээд явахдаа намайг дивизийн штабт томилуулснаар би 1983 оноос штабын /удирдах/ ажилтан болох гараагаа эхлүүлсэн юм.



Ер нь "Эзэн хичээвэл, заяа хичээнэ" гэдэг үнэн үг. Хүн өмнөө тавьсан зорилготой байж, түүндээ хүрэхийн тулд цуцалтгүй зүтгэх хэрэгтэй. Би Зүүнбаянгийн дивиз /1981-1987 онд/-ээс маш их зүйлийг сурч мэдсэн бөгөөд тэр маань одоо ч амьдралд хэрэг болж байна. За тэгээд тэндээсээ Зөвлөлт Холбоот Улсад дээд сургуульд явсан, төгсөж ирээд батальоны захирагчаар ажиллаж байгаад 1993 оноос Батлан хамгаалах яаманд ажилласан. 1997 оноос Оросын Холбооны Улсын Москва хотын Цэргийн академид сурч, төгсөж ирээд хоёр анги удирдсан, мөн хэсэгхэн хугацаанд Цэргийн академид багшаар ажилласан. Үндсэндээ цэргийн бараг бүх шатны албан тушаалыг хашсан. 2010 онд Зэвсэгт хүчний Жанжин штабын Хүний нөөцийн хэлтсийн даргаар ажиллаж байгаад шинээр байгуулагдах Барилга-инженерийн ангийг зохион байгуулж, цуваагаар Баян-Өлгийг зорьж билээ. Улаанбаатар хотоос Баян-Өлгий аймгийн чиглэлд марш үйлдээд аймгийн төвөөсөө гурван км зайтай "Хүйтний ам" гэдэг газар хэд хоног байрласан. Шөнөдөө хүчтэй салхитай, цаг агаар тогтворгүй байсан ба бидний майхан шөнө нь нураад, өглөө босоод л дахин барьдаг байсан. Одоогийн энэ ангийг байгуулахад Өлгийд хоёр объект буюу Растан гуайн авто баазын объект, Шариф гуайн аймгийн барилгын үйлдвэрийн объектыг үзээд Авто баазын барилгыг сонгон, 2010 оны 8 дугаар сарын 5-ны өдөр нүүж богино хугацаанд цэргийн анги болгон өөрчлөх их ажлыг эхлүүлсэн юм. Мэдээж олон жил ашиглаагүй объектыг байгууллага болгон төвхнүүлэх хэцүү байсан. Бүгдээрээ хөдөлмөрлөж, миний бие байрны гаднаширээ, сандлаа тавиад, модны сүүдэр дагаж нүүгээд бүх зүйлээ харж, удирддаг байв. 2010 оны 8 дугаар сарын дундуур аагим халуун хурц наранд гадаа ажилласан цэргүүдийн маань гэдэс нь өвдөөд эмийн эмчилгээ хийсэн боловч үр дүн өгөөгүй юм. Гэдэс нь өвдсөн А.Хурметбек тэргүүтэй 10-аад цэргийг жагсаагаад "Талын хар" гэдэг архинаас тал хундагыг уулган эмчилж байсан гэх мэтийн дурсамжууд бий. Манай хамт олон хөдөлмөрч, дайчин шаргуу, үүнийг бид хийхээс өөр хэн хийх вэ, энэ бидний амьдрах, ажиллах гэр орон гэсэн хоёргүй сэтгэлээр өдөр, шөнөгүй ажилласаар 10 дугаар сар гэхэд орчноо бүрдүүлж уямар сайхруулан засан тохижуулаар 2011 онд Зэвсэгт

хүчний "Тэргүүний тохижилттой анги" болж билээ. Бид аймгийн бүтээн байгуулалтад оролцохын зэрэгцээ сургалт бэлтгэлээ өндөр хэмжээнд явуулснаар хоёр жил дараалан Зэвсэгт хүчний тэргүүний анги болсон юм. Мөн тус ангис зарим офицерууд нь Зэвсэгт хүчний Хяналт, шалгалт үнэлгээний газар болон бусад анги, салбаруудад албан тушаал дэвшин ажиллаж байгаа нь сайшаалтай. Ялангуяа улс орныхоо хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж, Асгатын мөнгөний ордны зам, гүүрийг богино хугацаанд чанарын өндөр түвшинд барьж өгсөн нь тус ангийн нэрийн хуудас болсон ажил гэж бодож явдаг. Ангийнхаа бүтээлч хамт олны буянаар 2014 оны 12 дугаар сард би Улаанбаатар хот руу одоогийн албан тушаалд томилогдон гуравхан сарын дараа генерал цолыг хүртэж байхдаа аав, ээж, ах, дүү, хамт олон, Алтай таван богдын болон Асгатын сүрлэг уулс, Өлгий хот, түүний сайхан ард түмэн маань нүдэнд харагдаж энэ бүхэндээ баярлаж, сүсэглэн биширч, гүнээ мэхийн ёслон хүндэтгэж байсан юм. Өдгөө ангийн хамт олон та бүхнийгээ үргэлж дурсаж явна. Монгол Улсын Зэвсэгт хүчний хөгжлийн түвшин шинэ шатанд гарч зэвсэглэл, техникээ шинэчлэх, сургалт бэлтгэлээ улам ахиулах, улс орны бүтээн байгуулалтад оролцох, эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг хэрэгжүүлэн, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын энэ талаар дэвшүүлсэн саналыг нүдээ олсон, зөв шийдвэр гэж боддог. Миний хувьд Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад үүрэг гүйцэтгэх Зэвсэгт хүчний 7781 дүгээр ангийг удирдан улс орныхоо бүтээн байгуулалт, хөгжил, цэцэглэлтэд үнэтэй хувь нэмрээ оруулахаар хүчин зүтгэж яваадаа туйлын их баяртай байна. Бидэнд итгэж хүлээлгэсэн энэхүү их хариуцлага, үүргийг нэр төртэйгөөр биелүүлэхийн төлөө чармайн зүтгэж, хичээж байгаагаа ирэлхийлэхэд таатай байна. Хамт олныхоо ажилд нь амжилт, амьдралд нь аз жаргал, эрүүл энх, энэ хорвоогийн хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе.

Зэвсэгт хүчний Ерөнхий хянан шалгагч, Хяналт, шалгалт үнэлгээний газрын дарга, бригадын генерал П.ДОРЖСҮРЭН

Урилга

Тус ангид ажиллаж, алба хааж байсан ахмадууд, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчид та бүхнийг Зэвсэгт хүчний 340 дүгээр анги үүсэн байгуулагдсаны түүхт 10 жилийн ойн ёслол хүндэтгэлийн ажиллагаанд хүрэлцэн ирэхийг урьж байна. Ёслол хүндэтгэл: 2020 оны 2 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд Баян-Өлгий аймагт болно. **Ойг зохион байгуулах комисс**

МӨРДЭСГҮЙ ЦЭРГИЙНХЭН

ЦААС “АТГАЖ” ТӨРСӨН ЭМЭГТЭЙ

Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд цэргийн алба хаагчдаас дутахааргүй үүрэг хариуцлага хүлээн ажлын голыг нь нугалж, ачааны хүндийг үүрдэг олон ажилтан алба хаагч бий. Тэдний төлөөлөл болгон зарим ажилтан алба хаагчийг онцолж байна.

ТҮҮНИЙ МӨРӨӨДӨЛ БИЕЛЭЭСЭЙ ...



Дарга, цэрэг ялгаагүй бүгдтэй нь мэнд устай, инээмсэглэл дүүрэн явдаг БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ аж ахуйн хэлтсийн үйлчлэгч Д.Нармандах ЗХЖШ-ын хашаанд 23 жилийн өмнө орж иржээ. Хэнтий аймгаас нийслэлд сэлгээд удаагүй байхдаа буюу дөнгөж 24-хэн настайдаа шүү. Харин тэр цагаас хойш хоёр охины ээж, хөөрхөн зээгийн эмээ болтлоо амьдралынхаа багагүй хугацааг ажил албандаа зориулсан байна. Түүний ярилцлагын хамгийн эхэнд онцлон хэлсэн үг нь “Үйлчлэгч гэдгээсээ би хэзээ ч ичиж байгаагүй. Цэл залуудаа ч тэр, одоо ч тэр. Ажил хүнийг голохоос, хүн ажлыг голдоггүй юм. Миний ажил миний бахархал” гэсэн юм. Тэрээр ажлын гараагаа БХЯ-ны нэг давхрыг цэвэрлэхээс эхлүүлж, дараа нь ЗХЖШ-ын коридор болон зарим хэлтсийн өрөөний цэвэр цэмцгэр байдлыг хариуцаж байгаад 10 жилийн өмнөөс БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ аж ахуйн хэлтэс, Гадаад хэлний сургалтын төв, хурлын танхим зэрэг нэгээс гурван давхар буюу гал тогооноос бусад бүх өрөө, тасалгааны цэвэрлэгээг хариуцдаг болжээ. Нарая эгч залуудаа Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаагийн өрөөг цэвэрлэдэг байснаа дурсаж, хуучны цэргийнхэн хүнлэг сайхан сэтгэлтэй, үйлчлэгч гэж ялгаж харьцдаггүй, өнгө дээгүүр дуугардаггүй мундаг хүмүүс байсан талаар дурдана лээ. Гэхдээ энэхүү залгамж халаа тасраагүй, хэлтсийнхэн нь болон ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, орлогч дарга нар болох хошууч генерал Р.Сүхбат, Ж.Бадамбазар, Сургалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Гантулга, Хүний нөөцийн хэлтсийн дарга, хурандаа Н.Гантөмөр тэргүүтэй цэргийнхэн өөрийнх нь ажлыг хүндэлдэгт баярлаж явдаг, хүн бүр ийм л байвал сайхан шүү гэлээ. Бидний ийн хөөрөлдөж байх үед Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалт явагдаж таарсан бөгөөд үүнийг дагаад тун завгүй болдог нь тодорхой байв. Хурал завсарлахаас өмнө ус буцалсан эсхийг шалгаж, кофе, цай, жигнэмгийг өрж байрлуулан, ойр орчмыг нь цэвэрлэж, өлгүүрийн уяа нь тасарсан зарим дүрэмт хувцсыг сайн дураараа хүртэл оёж байх юм. “Сэтгэл гэдэг жаахан зүйлээс ч харагдах ёстой” хэмээн үйл урлаж байхдаа хэлсэн үг нь одоо ч тод сонсогдох шиг ...

Түүний хэлснээр хамгийн завгүй үеүд нь 2, 7, 9, 11 дүгээр сар. Эдгээр сард цугларалт, сургалт их зохион байгуулагддаг учраас цэвэрлэгээнээс гадна туслах ажил нэмэгддэг байна. Харин

ажлын цаг нь 06.10-аас эхэлдэг бөгөөд 07.30 гэхэд хэлтсийнхээ 2-3 давхрын коридор, өрөөнүүдэд чийгтэй цэвэрлэгээ хийгээд дуусгачихдаг гэнэ. Үдээс хойш үргэлжлүүлээд л цэвэрлэгээндээ гарна. Энэхүү голдирол мэдээж өдөр бүр давтагдана.

Ажилсаг, хөдөлмөрч эгч маань Г.Шинэцэцэг, Г.Шинэзул хэмээх хоёр охин, П.Даваадорж гэдэг хөөрхөн зээ хүүтэй. Харамсалтай нь бага охин нь тавдугаар ангидаа нурууны гэмтлийн улмаас суугаа болсон тухай нулимстайгаа хамт өгүүлнэ лээ. “Миний охид ээж минь явал баярлах бол, ээж минь явал жаргалтай байх бол гээд их хичээдэг юм. Заримдаа бүр уйлтал минь сайхан үг хэлдэг. Охидынхоо их хайранд би жаргалтай яваа хүн. Хэдийгээр миний бага охин тэргэнцэрт суудаг болсон ч амьдралд итгэх итгэл нь маш их, ажилсаг хөдөлмөрч гэж жигтэйхэн шүү дээ. Ямар сайндаа ээждээ тусалж, өрхийн орлогоо нэмэгдүүлэхээр гар урлал хийдэг болсон. Охиддоо, зээдээ маш их хайртай. Элэг бүтэн, эрүүл байхад энэ амьдрал аяндаа сайхан болно оо” гэсэн нь түүний чин сэтгэлийн яриа байсан юм.

Түүнээс мөрөөдлийг нь асуухад хэсэг чимээгүй сууснаа “Энэ тухай олон жил бодож иржээ. Манайх Улиастайн 23 дугаар хороонд амьдардаг. Өндөр хүчдэлийн дор байдаг учраас газрын гэрчилгээ гардаггүй юм. Би боддог л доо. Олон жил БХЯ, ЗХЖШ-ын цэвэр цэмцгэр байдлаар өөрийн хөдөлмөр, бүтээлээ зориулан ажиллалаа. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлагууддаа учир байдлаа хэлээд, албан тушаалын орон сууцанд ч болов оруулж өгөөч гэвэл хэр хүлээж авах бол гэж боддог. Гэхдээ хэлж зүрхлээгүй л явна. Тэргэнцэрт суугаа охин бас бяцхан зээгийнхээ төлөө дэлхийг ч үүрээд явахад бэлэн байгаа ч заримдаа амьдрал санаснаар болохгүй юм. Хааяа энхийг сахиулагчид сайн үйлсийн аян өрнүүлж байгаа тухай дуулдаг. Энэ аян биднийг зориод ирээсэй гэж боддог л юм. Саяхан ЗХЖШ-ын АУГ-ын мэргэжилтэн, хошууч Ц.Энхцогт Афганистанаас ирээд цэргийн багараас нэгэн эмэгтэйд таван ханатай өргөө цагаан гэрийг тавилгатай нь хамт бэлэглэж байгааг хараад бахархаж л суулаа. Мэдээж манай хэлтсийнхэн түлээ нүүрсээс эхлээд бишгүй л их тусалж, дэмждэг. Энэ завшааныг ашиглаад баярлаж явдаг илэрхийлье. Атгасан гар шиг цул байж чаддаг, нэгнээ гэсэн сайхан сэтгэлтэй хамт олон доо” гээд сайхан үгсээр магтав. Залуу нас, хөдөлмөр зүтгэлээ Зэвсэгт хүчний үйлчилгээний албанд тасралтгүй зориулж яваа энэ дайчин эмэгтэйн мөрөөдөл биелээсэй гэдэг ерөөлөөр энэхүү нийтлэлээ төгсгөө.

Бидний дараагийн онцлох эрхэм бол ЗХЖШ-ын Захирааны удирдлагын хэлтсийн хэвлэгч, оператор П.Батжаргал. Түүний тухай хоёр тодорхойлолт олны дунд бий. Нэгдүгээрт, ЦНДС-ийн анхны эмэгтэй сонсогчдын нэг. Хоёрдугаарт, түүнээс ажил нь нэвт “үнэртдэг”. Эрхэлсэн ажлаа өөрөөсөө “үнэрттэл” нь хийж гүйцэтгэнэ гэдэг бол тэрээр энэ ажилдаа гаршсан гэдгийг нь илтгэнэ. Ийм л тодорхойлолтын эзэн П.Батжаргал гэдэг бүсгүй 1994 онд ЦНДС-д анхны эмэгтэй сонсогч болсноор түүний Зэвсэгт хүчинтэй холбогдсон түүх эхэлнэ. Дөнгөж 10 дугаар ангиа төгсөөд удаагүй байтал ээж Л.Хишигсайхан нь ажлаа тараад нэгэн мэдээтэй харьсан нь ЦНДС-д анх удаа эмэгтэй сонсогч бүртгэж авна гэсэн зар байв. Ээж нь БХЯ, ЗХЖШ-т үйлчлэгч хийдэг байсан бөгөөд охиноо цэргийн хүн болгох нь түүний мөрөөдөл байж. Ээжийнхээ ятгалгаар шалгалтуудыг нь давж, эмэгтэй офицер бэлтгэх сургуульд ороход түүнтэй хамт таван эмэгтэй сонсогч байсан нь Г.Болор, Г.Буянтогтох, Ц.Эрдэнэтуяа, Ц.Төгсжаргал, Ц.Содгэрэл нар бөгөөд тэд 100 гаруй эмэгтэйдээс шалгарчээ. Ингээд суралцаад байж байтал аав Д.Пүрэвсүрэн нь хавдар туссан таагүй мэдээ дуулдаг, авыгаа асарч тэтгэх ажил түүнд ногдсон байна. Аавыгаа



асарсны дараа нь эргээд хичээлдээ орж чадаагүй гэнэ. Мэдээж үүгээр Зэвсэгт хүчинтэй холбогдсон түүх тасрахгүй. 1996-1998 онд Зэвсэгт хүчний 013 дугаар ангид арван хурууны бичээчээр, түүний дараа Батлан хамгаалахын Төв архив зэрэг хэд хэдэн байгууллагад сэлгэн ажиллажээ. Тэр үед компьютер гэж байгаагүй, зөвхөн бичгийн машинаар бичдэг байж л дээ. Харин ЗХЖШ-тай 2001 оноос холбогдож, алба хаагчдаас ирүүлсэн албан бланк, төсөл,

заавар, журам, танилцуулга гээд хэвлүүлэх шаардлагатай бүх зүйлийг нь албан хэрэг хөтлөлтийн баримт бичгийн стандартад оруулан, үг үсэг, утга найруулгын алдааг нь хянаж хэвлэдэг болжээ. “ЗХЖШ-ынхан таныг нэг минут ч амраахгүй хайгаад байдаг юм билээ” гэхэд “Харин тэгдэг юм. Миний ажил цаг минуттаар хэмжигддэг онцлогтой. Өглөөнөөс орой хүртэл ямар ч завгүй. Ямар сайндаа манай залуучууд намайг “Өвдөх эрхгүй, үхэх ч эрхгүй хүн” гээд нэрлэхсэн байх вэ дээ. Зарим нь бүр “Чингис хаан төрөхдөө неж атгаж төрсөн гэсэн. Та төрөхдөө цаас атгаж төрсөн байх” гэж цаашлуулдаг юм. Нээрээ л цаас атгаж төрсөн хүн шиг бичиг цаастай холбоотой ажил минь барагдана гэж үгүй. Өдөрт дунджаар 300-500 орчим хуудсыг албан хэрэг хөтлөлтийн баримт бичгийн стандартад оруулж, үг, үсэг, утга найруулгын алдааг нь хянаад хэвлэнэ. Нэг ч үсэг алдах эрхгүй. Олон хүний ажил амьдралтай холбоотой тушаал, шийдвэр миний гараас гарч байгаа гэж бодохоор сайхан санагддаг” гэлээ. Тэрээр ажлаасаа эрч хүч, урам зориг авдаг тухайгаа ч хуучилсан. Амьдралынхаа үнэтэй цаг хорьмыг энэ хамт олны дунд, энэхүү ягаан байшиндаа өнгөрөөж байгаа гэж бодохоор хайрлахгүй байхын аргагүй. Ээж минь “Миний охин офицер болж чадаагүй ч эрхэлсэн албандаа тод мөртэй ажиллаж байгаа нь аштай юу даа” гэдэг юм. Ижийг минь БХЯ болон ЗХЖШ-ын энэ л ягаан байшинд насаараа үйлчлэгчээр ажилласан болохоор бүх зүйл нь дотно сайхан санагддаг шүү. Одоо ээж 70 гарсан сайхан буурал байна даа. Цаг завтай үедээ аль болох ээжтэйгээ хөөрөлдөж өнжихийг хичээдэг юм. Харин аав минь төмөр хүн замд насаараа ажилласан, олондоо нэр хүндтэй мундаг хүн байсан даа” гэв. Түүний ханийг Б.Батдаваа гэдэг цагдаагийн хошууч. Б.Батдаваа нь ЦНДС-ийн Цэргийн хөгжлийн сургуулийг төгссөн бөгөөд түүнийг Зэвсэгт хүчний 013 дугаар ангид ажиллаж байхад нь танилцсан гэнэ. Хожим цагдаад орсон бөгөөд өдгөө ЦЕГ-ын Хэрэг бүртгэх албанд ажилладаг юм байна. Тэд Б.Лхагва, Б.Хүслэн, Б.Билгүүтэй гэдэг нэг охин, хоёр хүүтэй. Хамгийн том нь 21 настай бол бага нь хоёрдугаар анги ажээ. Хөөрөлдөх зуур гаднаас ЗХЖШ-ын Хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн, ахлах дэслэгч Б.Болорсайхан “Батжа, эгч ээ” гэсээр гүйн орж ирэв. Албан бланк хэвлүүлэх гэнэ. Түүнийг ЗХЖШ-ынхан дарга, цэрэггүй “Батжа” гэж авгайлдаг юм байна. Түүнээс баримталдаг зарчмыг нь асуухад “Ямар ч ажлыг чин сэтгэлээсээ хийх ёстой. Сэтгэл шингэсэн ажил бүхний үйлс өөдөө байдаг юм. Хоёрт, ямар ч ажлыг хойшлуулж, овооруулах дургүй. Цаг цагт нь биелүүлээд явахыг урьтал болгодог доо. Гуравт, аль болох шударга байхыг хичээдэг. Магадгүй энэ зан офицер болоогүйтэй маань холбоотой байх. Цэргийн мэргэжлийн дээд байгууллагад ажиллаж байгаагийн хувьд цэргийн цолтой болох боломж байсан л байх. Гэхдээ миний хувьд нэгэнт цэргийн сургуулийг нь төгсөж чадаагүй учраас цэргийн цол зүүх нь зохимжгүй гэж боддог юм. Залууст хандаж хэлэхэд бүх зүйл цаг хугацаатай бөгөөд ажилдаа чин сэтгэлээ зориулбал амжилт ойрхон шүү” гэсэн юм. Ярилцлагаа дуусгахад өөр арга байсангүй. Учир нь түүний өрөөний үүдэнд аль хэдийн хүмүүс дугаарлаад эхэлчихэж. Тэр яг хэлсэн шигээ тун завгүй гэдэг нь үүнээс тун тодорхой харагдлаа.

"БУУНЫ ГУРАВ"-ЫН НЭГ

Зэвсэгт хүчиндээ “Бууны гурав” гэдгээрээ танигдсан гурван эр байдаг нь Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн цэргийн засварын цехийн Ж.Энхбат, Ч.Болд-Эрдэнэ, Х.Атар нар. Бууны засвар, үйлчилгээг хийхэд амьдралынхаа 40 гаруй жилийг зарцуулж яваа гурван найзын нэг нь болох Дорнод аймгийн харьяат Ч.Болд-Эрдэнэ г г р и л ц л а г а н х а а х о й м о р т у р ь л а а . Тэрээр 1977 онд Зэвсэгт хүчний 015 дугаар ангид гурван жилийн хугацаат цэргийн албыг хаасан байна. Ингэхдээ зэвсгийн мастерын дамжаанд давхар суралцаж төгссөн гэнэ. Халагдаж ирээд Ардын Армийн 165 дугаар ангиас ажлын гараагаа эхлүүлжээ. Тэр үед тухайн анги нь томоохон үйлдвэртэй байсан бөгөөд Зөвлөлтийн м э р г э ж и л т н ү д олноороо ажилладаг, ЗХУ-д суралцаад ирсэн залуухан офицер, ахлагч олонтой армийн тэргүүний анги байсан гэнэ. Хожмоо 2003 онд татан буугдахад нь суурин дээр нь үлдсэн ганц анги нь Зэвсэгт хүчний 011 дүгээр анги гэдгийг Ч.Болд-Эрдэнэ ярианыхаа эхэнд онцоллоо. Түүний төдийгөөс өдий хүртэл гүйцэтгэж ирсэн үүрэг нь буудлагын зэвсгийн засварт ирж байгаа буунуудад хар ислийн бүрхүүл суулгах аж. Хар ислийн бүрхүүл нь засварын сүүлийн дамжлага бөгөөд энэ нь бууг гоёмсог өнгөтэй болгохын зэрэгцээ



Зүүн гар талаас Ч.Болд-Эрдэнэ, Ж.Энхбат, Х.Атар

зэврэлтээс хамгаалдаг байна. Цэргийн ёслолын жагсаалд буутай алхах болоход “Бууны гурав”-ын эрэлт их нэмэгддэг гэнэ. Бууны засварын явцын тухай тодруулахад тэрээр “Буудлагын зэвсгийн засварчин эхлээд буугаа хүлээж авна. Дараа нь гэмтлийг нь тодорхойлж, засна. Зассаныхаа дараа модон эдлэлийг нь өнгөлж, лакдан буцаагаад угсарна. Эцэст нь буудлагад бэлэн болгоно гээд олон дамжлагатай. Дамжлага бүр мэргэшсэн алба хаагчидтай. Тухайлбал, манай Ж.Энхбат Зэвсэгт хүчинд 40 дэх жилдээ алба хааж байгаа мундаг чадалтай нөхөр. Гар бууг засварлахдаа үнэхээр гаргууд. Ямар ч эвдрэл гэмтэл байсан засчихдаг элдэвтэй эр. Харин Х.Атарын хувьд дуран гэрээлэлийн засварчин, туршин буудагч. Үүндээ хэнийг ч урдаа гишгүүлэхгүй гарамгай. Х.Атар бид хоёр 38 жилийн өмнөнэг даргын тушаалаар нэг өдөр томилогдож байсан түүхтэй. Бид гуравт нөхөрлөлийн өндөр ёс зүй бий. Үүнийгээ цэл

залуугаас өвгөн буурал болтлоо хэн ч зөрчиж байгаагүй” гэв. Тэд залуудаа хэд бол хэдэн зуун бууг засварлаж, өнгөлөн лакдаж, харлуулгыг нь хийдэг байсан гэнэ. “Танд ямар төрлийн буу байгаа вэ” гэхэд “Хамгийн хөгжилтэй нь бид гуравт буу байхгүй. Хүмүүс асуудаг л юм. Буу засаж, өнгөлдөг та нарын хувийн буунуудыг үзье гээд л. “Загасчны морь усгүй” гэдэг шиг юм болж байна” гэлээ. Тэрээр 38 жилийн өмнөх Зэвсэгт хүчинтэй харьцуулшгүй өөр болсон хэмээв. Картын бараанд шилжсэн тэр үед олон шилдэг офицер, ахлагч нар армиас гарч ганзагын наймаанд орсон. Харин цөөхөн хэдэн нөхөд цалинтай, цалингүй хэдэн жил л армийнхаа төлөө зүтгэсэн шүү дээ. Тэдний нэг нь бид гурав. Цалингүй хоёр жил орчим болж байснаа лав санаж байна гээд өнөөдрийн Зэвсэгт хүчний хөгжил, өнгө төрхөд сэтгэл хангалуун явдаг хэлж байлаа.

Ч.Болд-Эрдэнэ ахын хань Ч.Шүрэнцэцэг мөн л энэ ангид оёдолчноор залуу нас, хөдөлмөр зүтгэлээ зориулсан эмэгтэй байдаг гэнэ. Тэрээр саяхан тэтгэвэрт гарсан бөгөөд Дундговь аймгийн Гурван хайрхан сумын харьяат ажээ. Тэд Б.Алтан-Очир, Б.Алтансүх, Б.Алтангадаас, Б.Алтангэрэл гэдэг дөрвөн хүүтэй. Х ө в г ү ү д и й н х э э хоёрыг нь Зэвсэгт хүчний 013, 015 дугаар ангид хугацаат цэргийн албыг нь хаалгасан байна. Үүнийг тэрээр “Цэргийн салбарт ажиллаж байгаа хүн өөрөө ядаж эх оронч байх ёстой. Ялангуяа, үр хүүхдүүдээ цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлээр төлөвшихөд нь, эцэг, эхийнхээ ажлыг ойлгож, хүндэлдэг болгоход нь анхаарах хэрэгтэй. Энэхүү үзэл санаа манай салбарт маш их ажиглагддаг нь хамгийн сайхан” гэв. Хамт олныхоо тухай “Бүтээхийн төлөө заяагдсан хүмүүс. Намайг 23 настай ирэхэд хүлээж авсан дулаан уур амьсгал 63 хүрэхэд ч хэвээрээ. Хамт олны минь цаашдын үйлс өөдөө байг ээ” гэж өрөөлийн үгтэй магтсан юм. Тэрээр ирэх 5 дугаар сард гавьяаныхаа амралтад гарахаар төлөвлөсөн бөгөөд хамаг амьдралаа зориулсан гэж бодохоор орхиод гарахад тун хэцүү байна, миний залуу нас энэ л хашаанд өнгөрсөн дээ хэмээсэн нь хамт олон, хамтран зүтгэгчдээ хэр хайртайг илэрхийлэх биз ээ.

Жаврын цагаан салхи нь исгэрнэ
Хаврын урьхан салхи нь илбэнэ
Жанчхүүгийн даваа холын хол бий

Жаргалын төлөө амь эрсэдсэн баатрууд энд нойрсон бий ... гэсэн Төрийн шагналт, Ардын уран зохиолч П.Бадарчийн шүлгэнд гавьяат жүжигчин, хөгжмийн зохиолч Г.Тэрбиш аялгууг нь нягт зохируулан бүтээсэн нэгэн дууны аяз цээжинд хоногшжээ. Өчигдрийн юм өнөөдөр үгүй болох ч бий. Харин хэзээд мартагдашгүй түүхийн шаргал хуудсанд мөнхөд бичээтэй үеийн үед дуурсагдах баатарлаг үйлстнүүд эх орон, ард түмнийхээ хайр хүндэтгэлийг хүлээж байдаг. Өдгөөгөөс 75 жилийн тэртээ Чөлөөлөх дайны фронтод цэрэг эрсийн адил дарийн утааг үнэртэн дайны хүндийг туулж, ялалтын тугаа өргөсөн цорын ганц урлагийн байгууллага нь МАХЦ-ийн Дуу Танцны Ансамблийнхан билээ. Түүх сөхвөл, 1945 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улс Японы түрэмгийлэгчдийн эсрэг дайн зарлаж улс орон даяар дайны цагийн байдалд шилжин Цэргийн дуу танцны ансамблийг фронтод явуулах тухай Бүх цэргийн жанжны тушаал гарчээ. Энэхүү тушаал ёсоор хошууч М.Хундагаа даргатай Цэргийн дуу танцны ансамблийн 60 хүний бүрэлдэхүүнтэй групп байлдааны үүрэг даалгавар авч фронтыг зорьсон түүхтэй. 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин, цэргийн яруу найрагч П.Лувсан гуай дурсамжиндаа "8 дугаар сарын нарлаг нэг өдөр Цэргийн төв клубын түлээний хашаанд хоргодох байрны харилцах шуудуу ухаж байсан бидэн дээр жижүүрийн зарлага Лувсанбалдан ирж машин ирлээ гэлээ. Бид яаран клуб дээр очвол цоо шинэ гурван "Шевролет" загварын машин эгнэн зогсчихсон байв. Клубээр хөл үймээн ихтэй, эмэгтэйчүүд нагаан буу бүсэндээ зүүж толины өмнө тохируулж харагдана. Харин эрэгтэйчүүд нь урт урт винтов буу барьцгааж хайрцагтай сумыг дамжлан оруулж байлаа. Маргааш нь нөгөө "Шевролет" машинуудад жүжигчид сууцгааж бидний хэдэн хүн "ЗИС-5" машинд хэдэн шуудай талх, давсалсан загас, гахайн лаазалсан консерв ачиж "Хоёрдугаар фронт" хэмээн бидний нэрлэдэг зүүн зүгийг барин хөдөлж билээ. Маршийн цуваа хөдлөхийн өмнө бие бүрэлдэхүүний жагсаалын урд Ансамблийн дарга, 30 нас ч хүрээгүй цэл залуухан хошууч М.Хундагаа байлдааны үүргийг гал цогтойгоор өгч билээ. Та бүхэн эх орныхоо тусгаар тогтнолын төлөө дарийн утаа үнэртсэн дайны талбар руу нэг гартаа буу, нөгөө гартаа хувцас, хөгжмөө бариад явж байгаа бөгөөд цэрэг эрсийн нэгэн адил эх орныхоо байлдааны даалгаврыг нэр төртэй биелүүлэх болно. Энэхүү эх орныхоо эрхэм үүргийг үнэнч шударга агаад эрэлхэг зоригтойгоор биелүүлэх нь бидний ариун үүрэг, нэр төрийн хэрэг мөн. Ах, дүү армийн дайчид, чөлөөлөгдсөн орон нутгийн иргэдэд урлаг, соёлоор үйлчлэн эх орныхоо хөгжил, цэрэг армийн баатарлаг гавьяаг сурталчлах, тэднийг ая дууны эгшиг түрлэгээр зоригжуулан, ялалтад уриалах нь бидний байлдааны чухал үүрэг мөн гэжээ. Ингээд цэргийн Ансамблийнхан Улаанбаатар хотоос гарч Хэнтий, Сүхбаатар аймгийн нутгаар дайрч Их Хянганы давааг давсан ба Тэнгэр элсийг туулан Өвөр Монголын нутгаар Бүдвал ноёны хошуу, Бандид гэгээний хийдээр дайран өнгөрч зүүн хойд Хятадын нутаг Долон нуур хүрсэн. Бид нийтдээ 2000 км байлдааны марш үйлдэж Зөвлөлт-Монголын дайчид, Өвөр Монголын ард иргэдэд урлагаар үйлчлэн дайны хүнд бэрх замыг туулж билээ. Нутгийн хил даваад ороход сэтгэл нэг л хачин. Дайны их зам яван явсаар тод болж бид мөрдөн хөөх гол замтай нийллээ. Япончууд үндүй сүндүй зугтсан гэрч баримт болсон хуарангийн сэг суурь энд тэндгүй үзэгдэнэ. Шаргалтсан лут лут манхны ёроолоор усан замаг дүүрэн тэр газарт дардан зам гэж үгүй. Тэр манханд Японы нэг дивиз бүт цохигдон гарчээ. Тэр аймшигт элсэн цөлд бид арга буюу хонолоо. Гал түлж, гэрэл гаргаж болохгүй, хоорондоо чангаар ярихыг цээрлэнэ. Эрэгтэйчүүд нь буугаа сумлан харуулд гарч, хориглох шуудуу ухна. Мөн давхар манаа, харуул гаргав. Үүрийн бүдэг гэгээнээр цааш хөдөлж өөрийн армийн түр бааз дээр очлоо. Биднийг очсоноос хойш хоёр цагийн дараа ард явсан машиныг тэр элсэнд дэлбэлж хоёр хүний амь насыг сүйтгэсэн мэдээ ирж билээ гэж

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

Ялалтын дууны хийгээд

Дайчин ансамбль

дурсан бичсэн нь бий. Цэргийн дуу танцны ансамблийнхан 1945 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр Долон нуурт байжээ. Дайн дууслаа гэсэн баярт мэдээ ирж Монгол-Зөвлөлтийн дайчид Өвөр Монголын ард иргэдэд зориулж ялалтын баярын концерт тогложээ. 1945 оны Чөлөөлөх дайнд тус ансамбль фронт дээр 22 удаагийн тоглолт хийжээ. Төрийн шагналт зохиолч Ч.Ойдов нь Чөлөөлөх дайнд Цэргийн Ансамблийн бүрэлдэхүүнд фронтын сурвалжлагчаар ажиллаж мэдээ, сурвалжилга бичсэнээс "Цэргийн чуулгынхан Өвөр Монголд тоглов" гэсэн нэртэй сурвалжилгадаа "Намрын жихүүн салхийг сөрөн довтлох дөрвөн машин уудам талд зэрэглээ адил сүүмэлзэн байгаа хийдийн зүг минут тутам ойртоно.

дөрвөн удаа тоглолт хийв. Тэд хариуд нь үндэсний бөхийн барилдаан үзүүлжээ. Манай ансамбль МАХЦ-ийн ангиуд, Зөвлөлтийн улаан армийн дайчдад өдөрт хоёроос гурван удаа тоглолт хийж чөлөөлөгдөн орны ард иргэдэд хувьсгалт орныхоо, Монгол-Зөвлөлтийн армийн тухай суртал нэвтрүүлгийг байнга хийж байв. Бид Шилийн голын чуулган, Цахар, Сөнөд, Бандид гэгээний хийд, Долон нуур хотоос баруун урагш байсан хээрийн ангиудад тоглолт үзүүлэв. "Эх орон", "Маргааш цэрэгт мордоно" найрал дуу, алдарт дуучин В.Пунцаг гуайн дуулсан "Өвгөн шувуу", "Хоёр бор", дуучин Пүрэвдолгорын дуулсан ардын дуу, П.Александрын шавь нартайгаа бүжиглэсэн монгол бүжиг, ардын дуу,

багш Гомбо гээд алдартнууд цуглажээ. Ансамблийн ерөнхий хормейстер, Ардын жүжигчин Д.Мясүрэн, ерөнхий удирдаач, УГЗ Ш.Гунаажав нар биечлэн концертын бэлтгэлийг хийлгэсэн. Энэ нь "Алдарт дайчин чуулга"-ын эхлэл болж уг чуулга байгуулагдсанаар өөрийн орон төдийгүй хилийн чанадад, Москва хотод ялалтын баярын үеэр тоглолт хийж Халимаг, Буриад улсуудад айлчлан тоглож үзэгчдийн талархлыг хүлээж байлаа. Бид өнөөдөр Цэргийн төв театр, МАХЦ-ийн дуу танцны ансамблийн өнгөрсөн түүхийг эргэн санаж алдар гавьяагаар нь бахархаж байна. Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчид Монгол Улсын соёл урлаг, шинжлэх ухааны байгууллагын нэрт зүтгэлтнүүд болж улс орныхоо хөгжилд үнэтэй хувь



Энэ бол Өвөр Монголын Шилийн голын чуулганы Бандид гэгээний хийд ажээ. Хийдийн өмнө талаар Шилийн гол урсана. Энд япончууд шийтгэх газар байгуулж, цэргийн гарнизон ухрахдаа орон байр, хамаг юмаа дэлбэлж шатаагаад явсан тул эвдэрхий балгас үлджээ. Үдийн алдад Ардын цэргийн төв клубын ухуулах асруудад олон лам, ноёдирцгээн сонирхож байлаа. Хийдийг мэдэгч их ламаас бидэнд хэлсэн нь "Цэргийн дарга ноёд оо, одоо цогчин дуганы хурал гадааллаа гэлээ. Том хэнгэрэг дэлдэн чимээ гарав. Удалгүй тал бүрээс лам хар олон хүмүүс ирж цугларан Ардын хувьсгалт цэргийн уран сайхны тоглолтыг сонирхон үзэхээр баяр хөөр болж байлаа. Тоглолт эхлэв. Өөрийн үндэсний хэл дээр үндэснийхээ бүжиг наадмыг монгол хүмүүс ингэж сайхан дуулж, бүжиглэж байхыг анх удаа үзэж байгаа нь энэ ажээ. Цөм нүдээ бүлтийлгэн амьсгаа даран чагнана. Алдарт дуучин В.Пунцаг гуайг "Өвгөн шувуу" гэдэг дууг дуулахад нь нэг өвгөн лам "Энэ дуу уг нь ар газрын дуу байх. Бас манай энд ч дуулдаг юм. Гэвч энэ цагаан толгойтой хүн гуай шиг сайхан дуулдаг хүнийг ер үзэж сонсож явсангүй. Заримдаа буцаж яваа ангир шувууны дуу шиг яасан сайхан дуулна вэ" гэлээ. Хагацал зовлон их үзэж, уян зөөлөн сэтгэлтэй болчихсон эмэгтэйчүүд, өвгөд жаргалтай орны хээр талын уянгат сайхан дууг сонсоод тэсэлгүй нулимс унагаж үзэгдэнэ. Ардын Хувьсгалт цэргийн дуу бүжгийн чуулга ард олны гуйсан ёсоор хоёр хоног өнжиж

"Бид хөдөлмөрлөнө", "Сэлэмт бүжиг" болон Д.Цэрмаагийн хөгжимдсөн "Сарны туяа" орос ардын аялгуу үзэгчдээс өндөр үнэлэлт авч, алга ташилтын хур буулгаж байлаа. Гавьяат жүжигчин, морин хуурч Г.Дамбийжанцан гуай дурсахдаа Хошууны ноён Будвал тоглолтын дараа манайхныг гэртээ очихыг урив. Тэр ноён Монгол-Зөвлөлтийн ангиудад агт морь, хоол хүнсний туслалцаа үзүүлж байснаа яриад бидний машинд сууж явахдаа "Шивээ хиагт", "Магнаг үсэгтэй туг" дууг их эвтэйхэн аялж байлаа. Ноёны улаан халзтай том гэрт биднийг урьж хоёр хонь гарган ууц тавин боов идээ будаагаар дайлан ба бидний явахад хүн бүрт луут архи бэлэглэсэн. Тэр ноён үнэхээр ардагч, Монгол Улсад дагаар орохыг хүсэж байснаа сүүлд Хятадын Засгийн газраас дургүйцэн үзэн ядагдаж байсныг хожим бид дуулсан юм" гэж бичжээ. 1986 оны цэргийн баяраар Цэргийн театр, Ардын цэргийн дуу танцны ансамблийн ахмад жүжигчид бараг л 100 шахам хүн цуглаж дуулиантай концертыг бэлтгэн тоглосон. Уг концертыг санаачлан зохион байгуулагч нь Ансамблийн дарга байсан ахмад дайчин Х.Ёндон гуай. Надад концертыг найруулах үүрэг оногдсон билээ. Энэхүү концертод Ардын жүжигчин Д.Дамдинсүрэн, Ардын жүжигчин Хивадогдой "Цэргийн 15 нас" жүжигт Жанжин Д.Сүхбаатарын дүрийг бүтээсэн Дашзэвэг, "Аман хуур" киноны Соном өвгөнд тоглосон алдартай жүжигчин Цэрэнлхүндэв гуай, хөгжмийн

нэмэр оруулсныг мартах учиргүй. Тухайлбал, монгол бүжгийн хаан гэгддэг Төрийн шагналт, Ардын жүжигчин Ц.Сэвжид, гавьяат жүжигчин В.Гомбо, Ё.Цэрэндулам, Д.Цэрмаа, Г.Дамбийжанцан, М.Дорж, С.Лувсангомбо, М.Хүүхээ, Төрийн шагналт, нэрт зохиолч Ч.Ойдов, 1939-1945 оны дайнд фронтын кино оператор Б.Дэмбэрэл нар байжээ. Дайн дуусаж энх цагийн бүтээн байгуулалтын он жилүүдэд тус ансамблиас Ц.Сэвжид, жүжигчин Дуламжав, нэрт найруулагч Ц.Раднаа зэрэг хүмүүс Төв Театрт шилжиж Эстрад концертын товчоо, Б.Элдэв-Очирын нэрэмжит кино театр үндэсний урлагийн их театр буюу Ардын дуу бүжгийн чуулгын найрал дууны багшаар З.Хасбат, Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнд түүхийн ухааны доктор Г.Цэрэндорж, Б.Элдэв-Очирын нэрэмжит кино театрын даргаар М.Хундагаа, нэрт найруулагч Н.Ёндонсамбуу, Монголын радиогоор Ч.Лхамсүрэнгийн "Хүрэн морь" найраглалыг хуучирч аянд аялгуулан хэлдэг багш Д.Гомбо Монголын радиод, алдарт дуучин В.Пунцаг гуай Төв аймгийн Батсүмбэр сумын клубын эрхлэгчээр, олон жил үр бүтээлтэй ажилласан Х.Ёндон Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яамдад аташагаар томилогдон дипломат албыг хашиж байжээ. "Хүмүүн төрөлхтөн", "Задгай цагаан" зэрэг нийтийн цэнгээнт бүжгийг дэглэсэн Цэргийн төв театр, ансамблийн нэрт жүжигчин П.Александр, Д.Зэвгээ нар Улаанбаатар хотын соёлын байгууллагад ажилласан байна. Энэхүү бахархалтай түүхийг бүтээсэн, Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчдыг дурсан хүндэтгэх, алдар гавьяаг нь алдаршуулах зорилгын үүднээс баримтат кино бүтээхээр ЦДБЭЧ-ын захиргааны хамт олон санаачлан ажиллаж байгааг төр, засгийн зүгээс дэмжинэ гэдэг итгэж байна. Ялалтын тугийг өргөлцөж яруу дуугаа өргөсөн ансамблийн гавьяаг залуу хойч үеийнхэн дурсан санаж, хүндэтгэх учиртай. **Дарь үнэртсэн ганц тайз минь Дайсантай тулсан ганц цайз минь Цэнхэр дурданг дуулахад Цэцэг тэвэрсэн тайз минь** **ЦДБЭЧ-ын найруулагч асан, чөлөөнд байгаа хошууч С.БОЛД**

Шинэ зэвсэг, техник



ӨӨРӨӨ ЯВАГЧ МИНОМЁТ "2С41" БУЮУ "ДРОК"

2015 оноос хойш яригдаж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр макет хэлбэрээр төсөөлүүлж байсан өөрөө явагч миномёт "2С41" буюу "Дрок"-ийг "Армия-2019" олон улсын зэвсэг, техникийн үзэсгэлэн дээр танилцуулсан. Мэдээж шинэ техникийг зэвсэглэлд нэвтрүүлэхийн тулд олон янзын туршилтыг явуулдаг. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар өөрөө явагч миномёт нь орчин үеийн өндөр хурд, маневртай, бага орон зайд явагдаж байгаа байлдааны ажиллагаанд нэн шаардлагатай үзүүлэлт, боломжуудыг шингээсэн аж. Өөрөө явагч миномёт "2С41" нь байлдааны хуягт машин "Тайфун" дээр

суурилагдан бүтээгдсэн тул минометоос гадна амьд хүчийг устгах зориулалт бүхий олон зэвсэглэлийг нэмэлтээр суурилуулах боломжтой талаар зохион бүтээгч нар нь дурдсан. **Тактик, техникийн өгөгдөхүүн:** Экипаж-4 хүн
Жин-14 тонн
Зэвсэглэл-82 мм-ийн миномёт
Буудлагын хурд-12 сум /нэг минутад/
Ойрын тусгал-100 метр
Холын тусгал-6000 метр
Орчуулсан ахмад Э.ОЧХҮҮ

Дугаарын зочин

Бидний сайн мэдэх "Хатанбаатар" уран сайхны киноны Баатарвангийн дүрээр Монголын ард түмэнд анх танигдсан жүжигчин, УДБЭТ-ын найруулагч асан, МУУГЗ Л.ЭРДЭНЭБУЛГАНТАЙ ярилцлаа.

Таны хүй цөглөсөн газар болох Булган аймгаас ярилцлагаа эхлүүлэх үү, олон ч анхдагчийг өлгийдөн авсан газар даа ...

-Юуны өмнө танай сонины хамт олонд баярлалаа. Батлан хамгаалах салбарынхан, тэр дундаа цэргийн сонины сурвалжлагчтай уулзаагүй их удсан байна. Бараг 50 гаруй жил болжээ. Би Монгол Улсынхаа хойморт нь аж төрдөг хүн байхгүй юу. Томруулж яривал Булган аймаг, жижигрүүлвээс Бугат сумын уугуул. Бугат сумын Бухын голд төрж өссөн. Энэ хоймор нутгаас Монголын суу билиг хүмүүс олноор төрж гарцгаасныг ард түмэн надаар хэлүүлэлтгүй мэднэ дээ. Үүнийг би өөрийн нэг насны бахархал гэж ойлгодог. Цогт хун тайж, хошой Чин ван Ханддорж, Монгол Улсын Ерөнхий сайд агсан Агданбуугийн Амар, Хувьсгалт цэргийн жанжин, Батлан хамгаалахын анхны сайд, Ардын Хатанбаатар С.Магсаржав, залуу жанжин Ж.Лхагвасүрэн, эрдэмтэн мэргэдээс С.Удвал, Ш.Гаадамба гээд тоочоод байвал бий. Ер нь 30 гаруй анхдагч төрсөн байдаг. Сансарт ниссэн анхны монгол хүн, БНМАУ, ЗХУ-ын баатар, чөлөөнд байгаа хошууч генерал Ж.Гуррагчаа, олимпчин аварга, МУГТ Н.Түвшинбаяраас гадна холимог тулааны "One championship", "Legend FC" холбооны дэлхийн аварга МУГТ Ж.Нарантунгалаг нь анхдагчид хэмээх эрхмүүдийн тоонд зүй ёсоор багтана.

Таны бүтээсэн "Хатанбаатар" уран сайхны

юм билээ. Харин би Ленинград хотод Хөгжмийн дээд сургуульд сурч байхдаа ингээд асуудал дууслаа, одоо ч намайг мартсан байлгүй гэж бодож байлаа. Гэтэл төгсөөд ирсний дараагаар найруулагч надтай ахин уулзсан. Ингээд анх Хатанбаатар Магсаржавын дүрд тоглохоор болж билээ. Тухайн үед Н.Цэгмид багш намайг хөтлөх шахам явж төв номын сан, цэргийн номын сангаар дагуулж дүртэй минь танилцуулж, судалгаа хийлгэдэг байлаа. Н.Цэгмид гуай монгол бичгээр уншсанаа хөрвүүлж, тайлбарлана. Надад ямар юмных нь монгол бичгийн боловсрол байх вэ. Тэгээд хамгийн сүүлд Ардын Хатанбаатар С.Магсаржавын бунхан дээр сийлсэн маршал Х.Чойбалсангийн хэлсэн үгийг орчуулж өгсөн. Үндсэндээ дүрийн судалгаа ингэж дууссан. Мөн киноны эх зохиол болох С.Удвал гуайн "Их заяа" романыг уншиж, мэдлэгээ ч баяжуулаад амжсан юм.

Энэхүү кино, нэн ялангуяа Баатарвангийн дүр тухайн үеийн хүүхэд, залуусыг цэрэг-эх оронч үзлээр хүмүүжүүлэх, эх орноо хайрлах, тусгаар тогтнолын үнэ цэнийг мэдрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Харин таны хувьд ...

-Өөрийгөө их азтай хүн гэж боддог. Юу гэхээр, тус уран бүтээлийн ачаар Монголын сор болсон, гайхалтай уран бүтээлчидтэй нэг баг болж ажилласан. Жишээлбэл, С.Гэндэн, Д.Чимэд-Осор, Б.Лоовой, П.Цэрэндагва, Н.Сувд

Л.Эрдэнэбулган: БААТАРВАНГИЙН ДҮР МИНИЙ АМЬДРАЛД ЭРГЭЛТ ХИЙСЭН



С.Удвал гуайн зохиолд ч тодорхой тусгагдсан байдаг.

Бүтээсэндүр, найруулсан жүжиг, кино, уран бүтээлүүдээс тань монгол омогшил, түүх, соёл, ёс заншил мэдрэгдэхийн зэрэгцээ зонхилох нь цэрэг, эх орны сэдэвтэй байх юм. Энэ талаар ...

-Миний хүүхэд ахуй, залуу нас их бужигнаан дунд ийш тийшээ үсчиг өнгөрсөн. Ер нь захирлын өрөөнд долоон хоногт нэг удаа дуудагдахгүй л бол тэс ондоо Л.Эрдэнэбулган болчих юм шиг санагддаг байв. Сүүлд л би гэдэг хүн овоо зүгширсэн. Ялангуяа уран бүтээлийн амтанд орсноор тэр шүү дээ. Нэг удаа концертын танхимд тоглолтын үеэр миний араас хэн нэгэн "Хөөө Тойлоо" гэх шиг боллоо. Олон жилийн өмнө намайг тэгж хочилдог байснаас биш одоо мэдэх хүн үгүй дээ гэж бодоод эргэж хартал хэн ч байсангүй. Ахиад л Тойлоо гэж дуудлаа, би тоосон ч үгүй. Гэтэл сүүлд Д.Сосорбарам надтай ирж уулзаад "Таныг багад тань Тойлоо гэдэг байсан юм уу" гэж асуухад нь гайхаад өнөөх гайхал чи байх нь "яаж мэдсэн юм" гээд нүдээ байдгаараа бүлтийлгэв. Тэгтэл Д.Сосорбарам миний сурч байсан сургуулийн багшийн гэрт хэсэг амьдарсан юм билээ. Манай багш л "Энэ Эрдэнэбулганыг яаж хүн болно оо гээд их санаа зовнидог байсан сан. Хүн ингэж өөрчлөгдөх гэж" гээд Д.Сосорбарамд багын Тоолойг дурссан байх нь тэр. Д.Сосорбарам ч их шооч хүн тул "Ер нь та их гүйдэлтэй, өдий зэрэгтэй ч байхааргүй хүн байсан юм байна лээ" гээд хөхөрч байсан. Уран бүтээлүүд сэдэв, агуулгын хувьд өөрт тань тэгж ажиглагдсан бол зөв. Надад учиргүй тийм үндсэрхэг үзэл байхгүй. Гэхдээ эх орон, газар шороо, нутаг усаа гэсэн үзэл их чамбай суусан. Хар нялхаасаа малын захад байсан нь ч бас нөлөөлсөн биз.

Жүжигчин хүний ажлыг сэтгэл зүйч, түүхч, хүн судлаач гээд олон талын үүрэгтэй гэж Д.Сосорбарам гуай "Монгол тулгатны зуун эрхэм" нэвтрүүлэгт оролцох үеэрээ хэлж байсан. Харин манайд үзэгчдийн боловсрол ямар түвшинд байгааг сонирхож байв уу?

-Түүхэн жүжиг, киног найруулж тавихын тулд найруулагч хүн эрдэмтэн болдоггүй юм гэхэд гологдохооргүй ойлголттой болох ёстой. Тэгж байж бусдад өндөр шаардлага тавьж сурна. Л.Лхасүрэн, Н.Намхайцэрэн, Д.Лувсаншарав, Ж.Чулуун гээд төлөвшил, хүмүүжлийн уурхай

болсон олон хүн энэ театрт нэг насны амьдралаа зориулсан. Ахмад үетэйгээ ойр байх нь зөв, бурууг тунгаах шүүлтүүртэй болно гэсэн үг. Би ч тэдний дэргэд суралцаж, боловсорсон учраас хүн болж төлөвшсөн гэж боддог. Басхүү театрынхаа буянд гадаадын хоёр дээд сургууль төгссөн. Тэгэхээр тодорхой хэмжээний боловсрол олжээ гэсэн үг. Нэмж хэлэхэд, миний хийсэн уран бүтээл үзэгчдэд таалагдаж ч, болно таалагдахгүй ч байж болно. Ямартаа ч тодорхой хэмжээний сэтгэлийн таашаал авахын сацуу амьдралын үнэн худал, зөв бурууг тунгаагаасай гэж хүсдэг. Жишээ нь хөгжмийн зохиолч Ц.Нацагдоржийн "Үүлэн заяа" дууриас төрт ёс, ах зах, дэг жаяг, ёс жудаг гэж юу болох нь их тодорхой харагддаг юм. Мөн суут найрагч Д.Нацагдоржийн "Ламбугайн нулимс" өгүүллэгийг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэн, Төрийн соёрхолт хөгжмийн зохиолч Х.Билэгжаргал нар маш том жүжиг болгож тавьсан. Хүний амьдралын, ахуйн соёлын маш том философийг, хайр сэтгэлийн үнэн худал, хүний мөс чанар зэргийг тус жүжгээс харж болно. Сонирхуулахад, "Ламбугайн нулимс"-ыг хошин өгүүлэл, эмгэнэлт гэдэг Ч.Лодойдамба, Ш.Гаадамба хоёр талцаж ном хаялцаад тэнцсэн гэнэ лээ. Үнэхээр ч тийм. Нэгэн бодлын хошинлолтой ч бас эмгэнэлтэй жүжиг. Дуурийн төгсгөлд босгоны шороотой хутгалдаж суусан лам хайртай бүсгүйдээ хандаж "Чи өөр хүнтэй явах чинь хамаагүй, гагцхүү намайг битгий орхиоц ээ" гэсэн энэ үгэн дээр үзэгчид нулимс унагахыг нэг биш удаа харж байлаа. Тиймээс энэхүү дуурь хүний сэтгэлд хүрсэн, цаашлаад хүнийг хүмүүжүүлэх, ёс суртахууны хувьд орон зайгаа олоход нь нэмэр болж байгаа юм.

УДБЭТ-ын даргаар ажиллаж байх хугацаандаа хэд хэдэн менежментийн сайжруулалтыг хийснээс гадна зарим ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дорвитой дэмжлэг үзүүлсэн гэж сонссон. Жишээлбэл, нэг өдрийн дотор 35 айлыг орон сууцанд оруулсан явдал ...

-Монголд эстрад урлаг хөгжиж байх тэр цаг үед манай театрт "Үүрийн туяа" гэж хамтлаг байлаа. Ахлахч нь нэрт дуучин МУГЖ Ц.Дагванамдал гуайн хүү УГЗ Баатар байсан. Ерөнхийдөө театрынхаа орлого, үзвэрийн төлөвлөгөөг нугалдаг байв. Түүхчид хааяа дурсаж байвал зүгээр санагддаг. "Үүрийн туяа"-гийнханд очоогүй газар гэж цөөн. Би ч хамт явах үе бий. Хамтлагийн залуус маань ёстой л шижигнэдэг байлаа. Тэднийхээ хөдөлмөрийг бодитой үнэлмээр санагддаг байлаа. Тэгээд долоо хоногийн чөлөө, бас машин өгөөд Улаан-Үд хот руу явуулахдаа "Чадал чинь хүрвэл та нар тоглолт хийгээд орлогоо өөрсдөдөө ав" гээд гаргаж өгч байсан. Энэ бол хөдөлмөрийг үнэлж буй хэлбэр болохоос миний сайн, муугийнх биш юм. Театрын орлогч дарга О.Энхтуяа гэж ёстой гярхай, ажигч бүсгүй байв. Нэг өдөр ажилчдын байраар ороод гарч л дээ, бага зэрэг эмзэглэж

зарим асуудалд анхаарлаа хандуулах хэрэгтэй гэж бодсон юм шиг байна лээ. Тэр үед нь би театрын даргаар томилогдож, орлогчтойгоо хамт тухайн үеийн хотын захирагч Л.Энэбишээс том дэмжлэг авч 35 айлыг орон сууцжуулж билээ. Энэ мэтчилэн хийсэн ганц хоёр зүйл бий.

Генерал Сатогийн дүр таны хувьд цор ганц эсрэг дүр. Энэ дүрд тоглох саналыг хэрхэн хүлээж авсан бэ?

-Г.Жигжидсүрэн найруулагч за гэвэл ёогүй. Ер нь тийм чадварлаг, гайхалтай уран бүтээлчтэй нэг баг болж ажиллаж байснаа өөрт оногдсон аз завшаан, хувь тохиол гэж ойлгодог. Анх танилцаж "Хатанбаатар" кинонд тоглосноос хойш дотно найзалж нөхөрлөх болсон, одоо бол миний хамгийн дотнын нөхөр. Тэр хүний мэлмийд миний дүр төрх гайгүй бууж, үр чадварын хувьд бас гологдохооргүй байсан юм байлгүй дээ гэж боддог. Генерал Сатогийн дүрд тоглоход монгол хүний займчиж явдаг шинж чанар нь бага зэрэг харшилсан. Бусдаар бол дүрдээ тэнцэхгүй, болохгүй гэсэн шүүмжлэл сонсож байгаагүй.

УДБЭТ-ын ирээдүйн хөгжил болоод залуу боловсон хүчний талаар таны бодлыг сонсьё ...

-Театртаа өнгөрүүлсэн цаг хугацаа, хийж бүтээсэн зүйлдээ маш сэтгэл хангалуун байдаг. Залуусыг ч тийм байгаагүй гэж хүсдэг. УДБЭТ гэсэн хурдны галт тэрэг замдаа гарсан. Үүний нэг жишээ нь Д.Амартүвшин, дэлхийд нэртэй хамгийн том театруудад өөрийн орон зайгаа бий болгочихсон явж байна. Харин мэргэжлийн боловсон хүчний хувьд асуудал бий. Хуучин цагт боловсон хүчнээ төр тодорхой хэмжээгээр бэлтгэдэг байсан бол одоо өөр болж. Тэгэхээр зарим зүйл дээр төрийн бодлого үгүйсгэгдэж байна. Ихэнх улс оронд төр нь сонгодог урлагийн театруудаа их бага хэмжээгээр дэмжиж ажилладаг. Өнөөдөр УДБЭТ-т хамгийн чухал мэргэжил болох удирдаач, балетмэстр, найруулагч ховордчихсон. Иймээс бид улс төржсөн, намчирхсан үзэл, томилгооноос ангид байх ёстой.

Сүүлчийн асуултыг танд үлдээе ...

-Би Монголын Ардын Армийн Улс төрийн газрын Соёл урлагийн хэлтсийн даргаар ажиллаж байсан чөлөөнд байгаа хурдан Д.Болдтой 60 гаруй жил нөхөрлөж байна. Бид хоёр хөдөлмөрийн гараагаа улсын Хөгжимт драмын театраас эхэлсэн. Харин дараа нь Ардын Армид хамт алба хаахыг хүсэх болсон. Тэгээд Болгар улсад сургууль төгсөж ирчихээд Цэргийн ансамбльд орно гэж агсам тавьж ч байсан удаатай. Ер нь мөрдэс зүүхийг их хүсдэг байж билээ. Гэвч хүслээр болоогүй юм. Миний бодлоор, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн маань олон улсад энхийг сахиулдаг болсон нь дэлхийд Монгол Улсаа сурталчлан нэр хүндийг нь өргөхөд маш том үүрэг гүйцэтгэж байна. Бидний бахархал яах аргагүй мөнөөс мөн.

Ярилцсанд баярлалаа. Ц.ЭНХ-ОРГИЛ



МУУГЗ Л.Эрдэнэбулган МАА-ийн Улс төрийн газрын Соёл урлагийн хэлтсийн дарга асан, чөлөөнд байгаа хурандаа Д.Болд нар. 2020 он

киноны Баатарвангийн дүрээс зөөлөн ааш, аяг их мэдрэгддэг. Өрхийн тэргүүн, сайн аав ч гэж хэлмээр. Энэ дүрд тоглохын өмнө бие болоод сэтгэл зүйн хувьд өөрийгөө хэрхэн бэлдсэн бэ?


-Нэг өдөр ажлаа тараад Ленин клубийн автобусны буудал дээр зогсож байтал өндөр шөвгөр залуу хүрч ирэн мэнд үс мэдсэнээ өөрийгөө кино найруулагч Г.Жигжидсүрэн гэж танилцууллаа. Тэгснээ шууд л намайг Хатанбаатар Магсаржавын дүрд тоглуулна гээд зүтгэчихсэн шүү. Намайг дүрдээ тэнцэх үгүйг нь та тэгээд шалгаж үзэхгүй юм уу гэж итгэлгүйхэн хэлтэл би тэгдэг найруулагч биш л гэж байна. Ер нь анх тэгж таарсан цагаас хойш намайг тус дүрд тоглуулна гэсэн байр суурин дээрээ бат үлдсэн

гээд нэрлээд байвал олон. Өөрөөр хэлбэл, дов довондоо байсан хүмүүс нэг зорилгын доор нэгдэж, гар нийлэн ажилласнаар бие биесээ улам дотно таньж мэддэг болсон гэх үү дээ. Миний хувьд итгэл муутай байсан ч түүнийгээ идэвх, зүтгэлээрээ нөхсөн гэж боддог. Кино олны хүртээл болсны дараагаар намайг нэрээр минь биш Баатарван гэж дуудах нь их сайхан сэтгэгдэл төрж, Эрдэнэбулган минь чи ч их хувь тохиолтой учирсан азтай хүн юм даа гэж бодогдсон.

Таны бие хүн дүрээсээ хэр ялгаатай санагдсан бэ?

-Эгэлгүй тийм хүнтэй би яаж ойрхон очих вэ. Цэргийн суут удирдагчаас гадна номонд нэвтэрхий, оюуны цараа ихтэй гээд олон янзын өнгөний хослол шиг хүн байсан санагддаг.

Үндэсний бахархал, өв соёл



Монгол ардын хувьсгалт цэргийн байлдагч, түрүүч, офицер, генералууд аа!

Өнөөдөр та нар өөрийн засгийн газрын тушаалаар манай эрх чөлөө, тусгаар тогтносон улсын хилийг давж, бүх Монголын заналт дайсан болсон Японы самурай нарын дарлагдлын доор зовж байгаа манай ах дүү дотоод Монгол, Баргын газар нутаг дээр орсон байна.

Та нар бол бүх монгол үндэстнийг чөлөөлж нэгдүүлэн тусгаар тогтносон бүрэн эрхт, нэгдмэл эрх чөлөөт улс болгохын тулд ариун шударга дайнд орсон байна.

Та нар болвоос нэгдсэн үндэстний талаар ах дүүгийн баатар Улаан Армитай мөр зэрэгцэн байлдаж, бүх дэлхийн ардчилсан улсуудын амгалан тайвангийн тул фашистын сүүлийн довтолон түрэмгийлэгч болох Японы эзэрхэг түрэмгийлэгчдийг устгахын тул байлдаж байна.

Би та нарыг манай эрх чөлөөт тусгаар тогтносон орныхоо гавьяат хөвгүүд байхыг уриалан дуудмуй.

Манай зөв үйл хэрэг, манай ард түмэн, манай эх орны төлөөнөө зоригтой эрэлхэг баатарлагаар тэмцэцгээ!

Манай ах дүү нарт эрх чөлөөг олгож буй манай хувьсгалын тугийг өндрөөр мандуулагтун!

Ардын хувьсгалт цэргийн нэр алдар, баатар үйлс мандтугай!

Цэргийн төмөр мэт хатуу сахилга батыг ёсчлон биелүүлэгтүн!

Монгол үндэстний хэв заншил, ахуй байдал, тэдний шашин шүтлэгийг нь гүйцэтгэн үзэгтүн!

Манай ялалтын тул урагш давшигтун!. Японы самурай нар сөнөтүгэй!. Эрх чөлөөт тусгаар тогтносон Монголын ард түмэн мандтугай!. Агуу их Сталин мандтугай!

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүх Зэвсэгт хүчний жанжин Улсын шалгарсан баатар, маршал Чойбалсан

Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгөөс. Улаан-Одон сонин. 1945.08.11. Дугаар 171 /2245/. Архивч-оператор Б.БЯМБАА

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 95 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин
редакцад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029